4			Батлагдсан маягт болон “эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт”-ын дагуу хог хаягдлын тоо бүртгэлээ тухай бүр хөтөлж, журмаар тогтоосон хугацаанд тайлангаа сумын Засаг даргад хүргүүлэх	МАК Аранжин Зэс ХХК нь төслийн үйл ажиллагаанаас үүсэж буй энгийн хог хаягдлыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны 12-р сарын 12-ны өдрийн А/349 дугаар тушаалын хавсралт “Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт”-ын дагуу сар бүр бүртгэж байна. Тайлант онд 9 дэд бүлэгт хамаарах 24 төрлийн хог хаягдал буюу 2,129.2кг энгийн хог хаягдал үүссэн байна. (Дэлгэрэнгүйг 3.1.1.4-с үзнэ үү.)
5			Төслийн талбай орчмын эргэн тойронд цэвэрлэгээ хийх	Төслийн талбай болон түүний ойр орчимд улирал бүр хог хаягдлын нэгдсэн цэвэрлэгээг зохион байгуулж байна. (Дэлгэрэнгүйг 3.1.1.5-с үзнэ үү.)
6	Аюултай хог хаягдал		Засвар, хяналтын ажлын үеэр хэрэглэсэн тос тосолгооны сав, цэвэрлэгээний бодис, эд анги дугуй зэрэг аюултай хог хаягдлыг ангилан ялгаж эх үүсвэр дээр түр хадгалах цэг байгуулах, тусгай зөвшөөрөл бүхий байгууллагатай гэрээ байгуулан устгуулах	<ul style="list-style-type: none">“МАК Аранжин Зэс” ХХК-ийн Цагаан суваргын катодын зэсийн үйлдвэр төслийн барилга угсралтын үе шат явагдаж байгаа бөгөөд аюултай хог хаягдал үүсгэж буй үйл ажиллагаанууд Эрдэнэс Цагаан Суварга ХХК-ийн объектууд дээр хийгдэж байна. Төслийн талбайд засвар үйлчилгээний төв болон анхан тусламжийн төвөөс аюултай хог хаягдал



		<p>үүсэж байна. Эдгээр аюултай хог хаягдал үүсэх цэгүүдэд аюултай хог хаягдал түр хадгалах цэгүүдийг байгуулсан.</p> <ul style="list-style-type: none">• Аюултай хог хаягдлыг 2024 оны 02-р сарын 20-ны өдөр “Түмэн Эгшиг” ХХК-тай байгуулсан “Аюултай хог хаягдал шилжүүлэх гэрээ”, 2023 оны 05-р сарын 01-ны өдөр Дорноговь аймгийн Мандах сумын Эрүүл мэндийн төвтэй байгуулсан “Эмнэлгийн тусгай хог хаягдлыг устгах гэрээ”-нуудийн дагуу шилжүүлж байна.• Тайлант онд төслийн үйл ажиллагаанаас 10,500кг хаягдал тос, 16.7кг эмнэлгийн халдвартай хог хаягдал, 2.1кг эмнэлгийн хурц үзүүртэй иртэй хог хаягдал үүсэж тусгай зөвшөөрөлтэй байгууллагуудад шилжүүлсэн байна.• Хог хаягдлын тухай хуулийн 21.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Байгаль орчны газрын 2024 оны 10-р сарын 02-ны өдрийн 61 дүгээр албан тоотоор Аюултай хог хаягдал үүсгэгчээр бүртгүүлж, Ү-001987 дугаар авсан.
7	Химийн бодисын сав баглаа боодлыг зөөх тээвэрлэх нөхцөлийг хангасан түгжээтэй, бат бөх багтаамжтай хүрэн өнгийн саванд хийх	2024 онд зөвхөн барилга угсралтын үйл ажиллагаа явагдсан тул ямар нэгэн төрлийн химийн бодис ашиглаагүй.

7.1.1 Ахуйн хог хаягдал

7.1.1.1 Хог хаягдлын ангилалт, ялгалт

Төслийн талбайд үүсэж буй нийт хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах ажлыг хэрэгжүүлэх нь хог хаягдлын дахин ашиглалт, дахин боловсруулалтыг хэрэгжүүлэх гол үндэс юм. Иймд төслийн талбайн хэмжээнд энгийн хог хаягдал үүсэх эх үүсвэрүүд буюу Эрдэнэс Цагаан Суваргын ажилчдын кемп, оффис, гал тогоо зэрэг газруудад ангилан ялгалттай хогийн савыг стандарт шаардлагын дагуу байрлуулаад байна.

Тайлант онд үйл ажиллагаанаас үүсэж буй энгийн хог хаягдлыг дараах 2 төрлөөр ангилан ялгаж байна. Үүнд:

- Дахин ашиглах боломжтой хог хаягдал (Хуванцар, мод, төмөр)
- Дахин ашиглах боломжгүй бусад хог хаягдал



Зураг 7-2. Төслийн талбайд байрлуулсан ангилан ялгалттай хогийн савнууд

Цагаан Суваргын төслийн хог хаягдлын менежментийн хүрээнд стандарт шаардлагад нийцүүлсэн ангилан ялгалттай хогийн савны тэмдэг:





Зураг 7-3. Ангилан ялгалттай хогийн савны тэмдэг, тэмдэглэгээ

7.1.1.2 Дахин ашиглах боломжтой хог хаягдал

МАК Аранжин Зэс ХХК нь төслийн талбайд үүсэж буй хог хаягдлын хэмжээг багасгах, дахин ашиглах, сэргээн ашиглах, дахин боловсруулах нөхцлийг бүрдүүлэх 3R зарчмыг баримтлан ажиллаж байна.



Зураг 7-4. Компанийн баримталж буй хог хаягдлын менежментийн зарчим

Дахин боловсруулах нөхцлийг бүрдүүлэх зарчмын дагуу “Төвшин сайхан мөнх” НҮТББ-д дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг нийлүүлэхээр гэрээг байгуулаад байна. Энэхүү гэрээний дагуу гялгар уут, бүх төрлийн хуванцар, лааз, цаасны хаягдлыг нийлүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд нэг удаадаа 3-4тонн дахивар хог хаягдал нийлүүлэх шаардлага тавигддаг тул тайлант онд хараахан дахивар нөөцийг нийлүүлээгүй, ангилан ялгах түр талбайд хадгалж байна.



МАК Аранжин Зэс ХХК-ийн Дорноговь аймгийн Мандах сумын нутагт орших Цагаан суваргын катодын зэсийн үйлдвэр төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан - 2024 он

БАТЛАВ
"ТӨШВИН САЙХАН МОНХ" НҮТБ-ИЙН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
С.ЭРЭНГИЙТ
2023 он 07 сар 26-дөр № 655-1123 Улаанбаатар хот

БАТЛАВ
"МОНГОЛЫН АЛТ" (МАК) ХХК-ИЙН
ЕРӨНХИЙ БОЛОВСГОО ГҮЙЦЭГЭХ
2023 он 07 сар 26-дөр № 655-1123 Улаанбаатар хот

ХОГ ХАЯГДАЛ НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

2023 он 07 сар 26-дөр № 655-1123 Улаанбаатар хот

Нэг талаас Монгол Улсын хуулийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа эрхэлж буй "Төвшин сайхан монх" НҮТБ (шашид "А тал" гэх), түүнийг тэвлэж Гүйцэтгэх захирал О.Лхагвасүрэн,

Нөгөө талаас Монгол Улсын хуулийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа эрхэлж буй "Монголын алт" (МАК) ХХК (шашид "Б тал" гэх), түүнийг тэвлэж Хангамж техник үйлчилгээний газрын захирал Д.Нинжбалдар, бид нар (шашид хамтад нь "Талуу" гэх) Монгол Улсын Иргэний хуулийг удирдлага болгон дөр дүрсэн нөхцөлийг харилцан тохиролцож энэхүү хамтран ажиллах гэрээ (шашид "Гэрээ" гэх)-г байгуулав.

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. Энэхүү гэрээний зорилго нь Б тал болон түүний охин, хараат мөн хамаарал бүхий компаниудаас гарах дахин боловсруулах боломжтой хаягдал (шашид "дахивар ноон" гэх)-г тогтмол хуримтлуулан А талд хүлээгдэж өгөгдөж хөдөөтэй харилцаанд Талуудын эрх, үүрэг, хариуцаагт тохирой болгон зохицуулахад оршино.
- 1.2. Талуудын эрх бүхий албан тушаалтан гэрээны газрын үсэг зураг, тамга дараг баталгаажуулсан өдрөөс эхлэн гэрээ хүчин төгөлдөр болно.
- 1.3. Энэхүү гэрээ нь дараах хавсралтуудтай байх бөгөөд эзгээр нь гэрээний салшгүй хэсэг байна. Үүнд:
Хавсралт № 1-Угийн задргаа.

ХОЁР ГЭРЭЭНИЙ ЗҮЙЛ, ХУГАЦАА

- 2.1. Энэхүү Гэрээний хүрээнд Б тал болон түүний охин, хараат мөн хамаарал бүхий компаниуд нь өөрсдийн үйл ажиллагаанаас гарах дахин боловсруулах боломжтой хаягдал (шашид "дахивар ноон" гэх)-ийг хуримтлуулан А талд хүлээгдэж өгнө.
- 2.2. А тал Б талын охин, хараат мөн хамаарал бүхий компаниудаас гарах дахинвар ноонийг захиалгын дагуу тохиролцсон хугацаанд очиж авна.
- 2.3. Нийлүүлэгч болон түүний охин, хараат, компани мөн түүний хамаарал бүхий компани гэдэгт дараах компаниудыг өвлөгнө. Үүнд:

№	Компани	Регистрийн дугаар
1	"Монголын Алт" (МАК) ХХК	2095025
2	"Хүрэн толгой коалт майнинг" ХХК	2697947
3	"МАК Цемент" ХХК	5830974
4	"Эрдэнэс цагаан суварга" ХХК	5824826
5	"МАК Аранжин зэс"	5849187
6	"Тру ти ар си" ХХК	6610188

- 2.4. Нэг удаагийн амтат нь 3-4 тонн хэмжээтэй байна.
- 2.5. Энэхүү гэрээг 2025 оны 05-р сарын 13-ний өдрөөс 2024 оны 07-р сарын 20-ний өдөр хүртэлх хугацаанд байгуулсан болно.
- 2.6. Гэрээг талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр хугацаанаас нь өмнө дуусгавар болгож болно.

Зураг 7-5. Дахин ашиглах боломжтой хог хаягдлыг нийлүүлэх гэрээ

7.1.1.3 Хог хаягдлын тээвэрлэлт

Дахин ашиглах боломжтой хог хаягдлаас бусад энгийн хог хаягдлыг Мандах сумын засаг даргатай 2024 оны 05-р сарын 13-ны өдөр байгуулсан Хог хаягдлын гэрээний дагуу төслийн талбайгаас тээвэрлүүлж байна.

БАТЛАВ
МАНДАХ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Б.УГТАХБАЯР
2024 оны 05 сарын 13-ний өдөр

"ЭРДЭНЭС ЦАГААН СУВАРГА" ХХК-ТАЙ
БАЙГУУЛАХ ХОГ ХАЯГДЛЫН ГЭРЭЭ

2024 оны 05 сарын 13 өдөр №01 079-5124 Төхөм баг

Нэг: Нийтлэг үндэслэл

1.1 Монгол Улсын Байгаль орчны хамгаалах тухай хууль, Хог хаягдлын тухай хуулийн 8 дүгээр зүйлийн 4, 10 дугаар зүйлийн 2 дахь заалт, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 02/09 дугаар тогтоол зэрэг нь энэхүү гэрээний эрх зүйн үндэслэл болно.

Энэхүү гэрээг нэг талаас Мандах сумын Засаг даргын Тамгын газрын дарга Ц.Сосор, нөгөө талаас "ЭРДЭНЭС ЦАГААН СУВАРГА" ХХК-ийн гүйцэтгэх захирал Г.Цогт нар харилцан тохиролцож байгуулав.

Хоёр: Гэрээний зорилго

2.1 Хог хаягдлын хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг санхүүрүүлж, төслийн орлогыг бүрдүүлэхэд оршино.

Гурав: Сумын Засаг даргын Тамгын газрын хүлээх эрх, үүрэг

- 3.1 Хог хаягдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих
- 3.2 Аж ахуйн нэгж байгууллагын хог хаягдал хаях түр цэгийг тогтоож, мөрдүүлэх
- 3.3 Хог хаягдал гаргасны төлбөрийг тухайн сарын 30-ны дотор төвлөрүүлэх, түүний хэрэгжилтэнд хяналт тавих

Дөрөв: "ЭРДЭНЭС ЦАГААН СУВАРГА" ХХК-ийн хүлээх эрх, үүрэг

Зураг 7-6. Энгийн хог хаягдлын гэрээ

655-1123 тоот гэрээний хавсралт №1

Үүний задргаа

ДАХИВАР НӨӨЦ	ҮНЭ - 1кг/г		
	Төв	Очиж авах	
ЗЭС	Гялгар	17500	8750
	Божир	18500	8250
ГУУЛЬ	Гууль	6500	3250
	Хайлш	3800	1900
ХАЙЛШ	Хөнгөн цагаан	3800	1900
	Радикатор	6500	3250
ТУГАЛГА	Шинэ	1500	750
	Божир	1000	500
АККУМЛЯТОР	Батерей	500	250
	Зузаан төмөр	200	100
ТӨМӨР	Нийгэм төмөр	200	100
	Ган	200	100
	Ширэм	200	100
	Тонг төхөөрөмж	+	+
БУСАД	Мотор, хрон	+	+
	Хаягдал машин		- 90.000Г-10явж # Курс - 10.000Г-30.000Г
ГЯЛГАР УУТ	Панет/бут савлагаа	1900	950
	Зөөлөн	600	300
ХУВАНЦАР	Ус, урдааны /PET/	350	175
	Духуйн зөөлөн /HDPE/	400	200
	Алдср, падсн /PP/	100	50
	Вакум цонхны /PVC/	300	150
	Хөөсөнцөр	-	-
ЦААС	Лааз	2000	1000
	Цагаан цаас	50	25
	Бор цаас	60	30

А талыг төлөөлж: Гүйцэтгэх захирал О.Лхагвасүрэн

Б талыг төлөөлж: ХТҮГ-ын Захирал Д.Нинжбалдар

- 4.1 Зориулалтын цагаас бусад газарт хог хаягдал хаяхгүй байх
- 4.2 Орчны газрынхоо хог хаягдлыг цэвэрлэх
- 4.3 Хог хаягдлын талаарх дүрэм, журам, стандартын шаардлагыг хангаж ажиллах
- 4.4 Үүсгэсэн хог хаягдал болон аюултай хог хаягдлын мэдээллийг нутгийн захиргааны байгууллагад үнэн зөв мэдээлж аюулгүй байдлыг хангах
- 4.5 Хог хаягдлыг ялган ангилж хэвших
- 4.6 Гэрээнд заасны дагуу сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/12 дугаар тогтоолоор баталсан хог хаягдал гаргасны сарын төлбөрийг 150,000 /нэг зуун тавин мянган төгрөг/-өөр тооцож төлбөрийн даалгаварын дагуу төлж барагдуулна.
Ажилчдын кемп 150000 төгрөг 12 сараар = 1,800,000 (Нэг сая найман зуун мянган төгрөг)

Тав: Бусад нөхцөл

- 5.1 Хог хаягдал гаргасны төлбөр өөрчлөгдсөн тохиолдолд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулна.
 - 5.2 Гэрээгээр 2024 оны төлбөр тооцогдоно. 2024 оны 12 сарын 31-ны өдрөөр гэрээний хугацаа дуусгавар болно.
- Гэрээ байгуулсан:**
- МАНДАХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Ц.СОСОР
Утас: 90185429
- "ЭРДЭНЭС ЦАГААН СУВАРГА" ХХК-НЫ ГҮЙЦЭГТЭХ ЗАХИРАЛ Г.ЦОГТ
Утас: 99117464

7.1.1.4 Хог хаяглын бүртгэл

МАК Аранжин Зэс ХХК нь төслийн үйл ажиллагаанаас үүсэж буй энгийн хог хаягдлыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны 12-р сарын 12-ны өдрийн А/349 дугаар тушаалын хавсралт “Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт”-ын дагуу сар бүр бүртгэж байна. Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалтын дагуу тайлант онд дараах төрлийн хог хаягдал үүссэн байна.

Хүснэгт 7-2. Тайлант онд төслийн үйл ажиллагаанаас үүссэн хог хаягдлын жагсаалт (Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалтын дагуу)


Хог хаягдлын бүлэг	Дэд бүлгийн код	Дэд бүлэг	Хог хаягдлын төрлийн код	Хог хаягдлын төрөл
Сав баглаа боодлын хаягдал: Шингээгч, бохир алчуур материал, фильтрийн материал, тусгайлан заагдаагүй хамгаалалтын хувцас	15 01	Сав баглаа боодол (ангиан ялгасан ахуйн сав баглаа боодлын хаягдал орно)	15 01 01	Цаасан болон кардонон сав баглаа боодол
			15 01 02	Хуванцар сав баглаа боодол
			15 01 03	Модон сав баглаа
			15 01 07	Шилэн сав
	15 02	Шингээгч, бохир алчуур материал, фильтрийн материал, тусгайлан заагдаагүй хамгаалалтын хувцас	15 01 08	Даавуун сав баглаа боодол
			15 02 02	15 02 01-д зааснаас бусад шингээгч, бохир алчуур материал, фильтрийн материал, тусгайлан заагдаагүй хамгаалалтын хувцас
			16 01 01	Ашиглалтаас гарсан машин механизм, тэдгээрийг задлах болон засварлах үйл ажиллагаанаас үүсэх хаягдал (13, 14, 16 06, 16 08-аас бусад)
			16 01 19	Тусгайлан заагдаагүй бусад эд анги
Бусад хог хаягдал	16 03	Гологдол болон ашиглагдаагүй бүтээгдэхүүн (хүнсний бүтээгдэхүүн хамаарна)	16 03 02	16 03 01-д зааснаас бусад органик биш хаягдал
			16 06 04	Шүлтийн батерей (16 06 03-аас бусад)
	16 06	Батарей, аккумулятор	16 06 05	Бусад төрлийн батарей, аккумулятор
			17 01 01	Бетон
Барилга, барилгын материалын хог хаягдал (бохирдсон газраас ухаж гаргасан хөрс орно)	17 02	Мод, шил, хуванцар	17 02 01	Мод
			17 02 02	Шил
			17 02 03	Хуванцар
Ахуйн хог хаягдал (түүнтэй найрлага, бүтцийн хувьд ижил үйлдвэр, үйлчилгээ,	20 01	Ангилж цуглуулсан хог хаягдал (15 01-ээс бусад)	20 01 01	Цаас, картон
			20 01 02	Шил
			20 01 03	Био задралд ордог хоол, хүнсний бүтээгдэхүүний



албан байгууллагын хог хаягдал)			хаягдал (гал тогоо, гуанз, ресторан, кафе гэх мэт)
		20 01 13	Хүнсний өөх тос
		20 01 22	20 01 21-д зааснаас бусад төрлийн батарей, аккумулятор
		20 01 27	Хуванцар
		20 03 01	Холимог ахуйн хог хаягдал
		20 03 05	Бохир ус цэвэрлэгээнээс гарсан хаягдал
20 03	Бусад ахуйн хог хаягдал	20 03 06	Овор ихтэй хог хаягдал

Хог хаягдлын хэмжээ

2024 онд МАК Аранжин Зэс ХХК-ийн 10-20 ажилчид Эрдэнэс Цагаан Суварга ХХК-ийн объектуудад байлаж ажилласан тул эх үүсвэр дээр үүсэж буй хог хаягдлын хэмжээг үндсэн уурхай буюу Цагаан суваргын төслийн дотоод маягтын дагуу тогтмол бүртгэн, хог хаягдлын хэмжээ, төрөлд хяналт тавьж байна. 2024 оны 10-р сарын байдлаар нийт 2,129.2кг хог хаягдал үүссэн байна.



Зураг 7-7. Хог хаягдлын бүртгэлийн маягт

Хүснэгт 7-3. Энгийн хог хаягдлын хэмжээ

Хугацаа, сар	Энгийн хог хаягдлын хэмжээ, кг
I сар	161.2
II сар	150.8
III сар	161.2
IV сар	192
V сар	248
VI сар	240
VII сар	248
VIII сар	248
IX сар	240
X сар	240




График 7-1. Энгийн хог хаягдлын хэмжээ, кг

7.1.1.5 Хог хаяглын нэгдсэн цэвэрлэгээ

Төслийн талбай болон түүний ойр орчимд улирал бүр хог хаягдлын нэгдсэн цэвэрлэгээг зохион байгуулж байна.



Зураг 7-8. Хог хаягдлын нэгдсэн цэвэрлэгээ

7.1.2 Аюултай хог хаягдал

“МАК Аранжин Зэс” ХХК-ийн Цагаан суваргын катодын зэсийн үйлдвэр төслийн барилга угсралтын үе шат явагдаж байгаа бөгөөд аюултай хог хаягдал үүсгэж буй үйл ажиллагаанууд Эрдэнэс Цагаан Суварга ХХК-ийн объектууд дээр хийгдэж байна. Үүнд:



- Засвар үйлчилгээний төв
- Анхан тусламжийн төв

Хог хаягдлын тухай хуулийн 21.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Байгаль орчны газрын 2024 оны 10-р сарын 02-ны өдрийн 61 дүгээр албан тоотойр Аюултай хог хаягдал үүсгэгчээр бүртгүүлж, Ү-001987 дугаар авсан (Хавсралт). Төслийн талбайн хэмжээнд дараах аюултай хог хаягдлууд үүсэж байна.

Хүснэгт 7-4. Төслийн үйл ажиллагаанаас үүсэж буй аюултай хог хаягдлын жагсаалт


Хог хаягдлын бүлэг	Дэд бүлгийн код	Хог хаягдлын дэд бүлэг	Хог хаягдлын төрлийн код	Хог хаягдлын төрөл	Аюулын зэрэглэл
Гадаргуу бүрэгч материал (будаг, лак, паалан, цавуу, чигжээс, хэвлэлийн будаг үйлдвэрлэх, бэлтгэх, тээвэрлэх, хэрэглэх үед үүсэх хаягдал)	08 03	Хэвлэлийн бэх үйлдвэрлэх, бэлтгэх, тээвэрлэх, хэрэглэх, арилгах үед үүсэх хаягдал	080308*	Хортой бодис агуулсан хэвлэлийн хорны хаягдал (картрижийн хамт)	Х
Хаягдал тос ба шингэн түлш (хүнсний тос, Д ба Л бүлгийн тос хамаарахгүй)	13 02	Хөдөлгүүр, хурдны хайрцагны болон тосолгооны тосны хаягдал	130205*	Хөдөлгүүр, хурдны хайрцагны болон тосолгооны бусад тос	А
	13 05	Шингэн түлшний хаягдал	130501*	Түлшний тос, дизель	А
			130502*	Бензин	А
			130503*	Бусад түлш (холимог түлш)	А
Сав баглаа боодлын хаягдал: Шингээгч, бохир алчуур материал, фильтрийн материал, тусгайлан заагдаагүй хамгаалалтын хувцас	15 01	Сав баглаа боодол (ангилян ялгасан ахуйн сав баглаа боодлын хаягдал орно)	150109*	Хортой бодисын үлдэгдэл агуулсан эсвэл бохирдсон сав баглаа боодол	А
	15 02	Шингээгч, бохир алчуур материал, фильтрийн материал, тусгайлан заагдаагүй хамгаалалтын хувцас	150201*	Хортой бодисоор бохирдсон шингээгч, бохир алчуур материал, фильтрийн материал, тусгайлан заагдаагүй хамгаалалтын хувцас	А
Бусад хог хаягдал	16 01	Ашиглалтаас гарсан машин, механизм, тэдгээрийг задлах болон засварлах үйл ажиллагаанаас үүсэх хаягдал (13, 14, 16 06, 16 08-аас бусад)	160104*	Тосны шүүр	А
			160110*	Тоормосны шингэн	А
	16 02	Цахилгаан болон цахим тоног төхөөрөмжийн хаягдал	160205*	16 01 01-16 01 04-д зааснаас бусад хортой бодис агуулсан хаягдал оног төхөөрөмж (16 06-д заасан батарей, аккумулятор болон мөнгөн үс агуулсан	А



				унтраагуур, катодын лампны шил гэх мэт аюултай гэж тэмдэглэсэн эд анги)	
			160601*	Хартугалгатай батарей, аккумулятор	A
	16 06	Батарей, аккумулятор	160602*	Никель-Кадмийн батарей	A
			160603*	Мөнгөн ус агуулсан батарей	A
Барилга, барилгын материалын хог хаягдал (бохирдсон газраас ухаж гаргасан хөрс орно)	17 05	Хөрс (бохирдсон газраас ухаж гаргасан хөрс орно), чулуу, хурдас	170501*	Хортой бодис агуулсан хөрс, чулуу	X

Засвар үйлчилгээний төв

Цагаан суваргын төслийн засвар үйлчилгээний төвөөс үүсэж буй аюултай хог хаягдлыг тусгай зөвшөөрөл бүхий “Түмэн Эгшиг” ХХК-тай 2024 оны 02-р сарын 20-ны өдөр байгуулсан “Аюултай хог хаягдал шилжүүлэх гэрээ”-ний дагуу төслийн талбайгаас тээвэрлүүлэн устгуулж байна.



Зураг 7-9. Аюултай хог хаягдал шилжүүлэх гэрээ (Хавсралт)

Түүнчлэн аюултай хог хаягдал үүсэх эх үүсвэр буюу засвар үйлчилгээний төвд аюултай хог хаягдлыг ангилан хаях хогийн савнуудыг байрлуулсан.



Зураг 7-10. Тосны шүүрнээс хаягдал тос ялгах тунгаагуур



Зураг 7-11. Тосны шүүрний хаягдал цуглуулах сав

Засвар үйлчилгээний төвөөс үүсэж буй хаягдал тос, түлшний хаягдлыг хаягдал тос хадгалах цэгт түр хадгалан тусгай зөвшөөрөл бүхий байгуулагад шилжүүлж байна. Тайлант онд 10,500кг ашигласан масло тосыг шилжүүлээд байна.



Зураг 7-12. Хаягдал тос түр хадгалах цэг



Зураг 7-13. Хаягдал тос шилжүүлж буй байдал

Байгаль орчин, ахуйт зохицуулалтын сайдын
2018 оны 02 сарын 02-ны өдрийн А/21 дугаар
тушаалын 1 дүгээр заваралт

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ХАЯГДЛАГЧИЙН ТАЛБАЙН БИЧИГ
№ 07/101
Дагалдан авчирсан дугаар
/мөхөөрсөнийг илгээгчийн үүрэг, хариуцаж/

1. Үүсгэгчийн талаарх мэдээлэл:
Аюултай хог хаягдал үүсгэгчийн бүртгэлийн дугаар: **МАК Арранжин Зэс ХХК**
Аюултай хог хаягдал үүсгэгч байгууллагын нэр: **МАК Арранжин Зэс ХХК**

2. Аюултай хог хаягдалыг хүлээн зөвшөөрч авсан:
Огноо нар: **Албан тушаалын** Гарын үсэг: **Огноо**
2024 он **07** сар **15** өдөр

3. Тээвэрлэгчийн талаарх мэдээлэл:
1) Тээврийн хэрэгсэл(ийн) үндэн дугаар: **187476M** Тээвэрлэгчийн бүртгэлийн дугаар: **0000022**

4. Аюултай хог хаягдалын талаарх мэдээлэл:

Аюултай хог хаягдалын нэр	Аюултай хог хаягдалын ангилал	Салбарын ангилал	Саны дугаар	Хэмжээ	Нэгж	Аюултай хог хаягдалын код
1. Аюултай хог хаягдал	X			10500 кг	кг	105M3
2.						
3.						
4.						

3. Тээвэрлэгч үед явуулах үүрэг хариуцаж авсан мэдээлэл:
Огноо **07** сар **15** өдөр

5. Аюултай хог хаягдалыг хүлээн зөвшөөрч авсан тээвэрлэгч:
1. Огноо нар: **В.Бат** Гарын үсэг: **В.Бат** 2024 он **07** сар **15** өдөр

6. Үл зохихлоо: **гүй**

8. Аюултай хог хаягдалыг хүлээн зөвшөөрч авсан үүсгэгчийн талаарх мэдээлэл:
Аж ахуйн нэгж(ийн) нэр: **ТҮМЭН ЭННЭГ ХХК**
Түмэн элсэг: **ХХК бүртгэлийн дугаар: +000022**
Аюултай хог хаягдалыг хүлээн авсан:
Огноо нар: **Түмэн элсэг ХХК** Албан тушаал: **Огноо**
2024 он 07 сар 15 өдөр

Зураг 7-14. Аюултай хог хаягдалын дагалдах бичиг

Анхан тусламжийн төв

Төслийн анхан тусламжийн төвөөс үүсэж буй эмнэлгийн аюултай хог хаягдлыг Эрүүл мэндийн сайдын 2017 оны 12-р сарын 12-ны өдрийн А/505-р тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, боловсруулах, устгах заавар”-ын дагуу төслийн талбайд түр хадгалан, Дорноговь аймгийн Мандах сумын Эрүүл мэндийн төвтэй байгуулсан “Эмнэлгийн тусгай хог хаягдлыг устгах гэрээ”-ний дагуу сумын эрүүл мэндийн байгууллагад шилжүүлж байна. Тайлант онд 16.7кг халдвартай хог хаягдал, 2.1кг хурц үзүүртэй хог хаягдал үүссэн байна.



МАК Аранжин Зэс ХХК-ийн Дорноговь аймгийн Мандах сумын нутаг орших
Цагаан суваргын катодын зэсийн үйлдвэр төслийн
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан - 2024 он

恒通集团
Heng Tong Group

Монгол улсын Эрүүл мэндийн сайн гэрээ 2017 оны 12 сарын 12 өдөр А/98 хүчин
Эрүүл мэндийн хөгжлийн үйлдвэр төслийн эрүүл мэндийн үзүүлэлт үнэмлэхийг хянах
хуульчилсан тухай акт
恒通蒙古铜矿项目门诊体检处理登记表

Эмгэгчдийн хөгжлийн бодлогоор урьдчилж үзүүлэх байгууллагад хүргэхэд өгөх бүртгэлийн маягт

Эрүүл мэндийн үйлдвэр төслийн эрүүл мэндийн үзүүлэлт үнэмлэхийг хянах тухай акт

Төрийн эрүүл мэндийн газар: 8576 988 404 79
Харьяат байр, утас: 470000

Эрүүл мэндийн байгууллагын нэр	Харьяат байр, утас	Хүрээлэнгийн эрүүл мэндийн үзүүлэлт үнэмлэхийг хянах	Эрүүл мэндийн үзүүлэлт үнэмлэхийг хянах	Эрүүл мэндийн үзүүлэлт үнэмлэхийг хянах	Хүрээлэнгийн эрүүл мэндийн үзүүлэлт үнэмлэхийг хянах	Хүрээлэнгийн эрүүл мэндийн үзүүлэлт үнэмлэхийг хянах
Монгол улсын Эрүүл мэндийн сайн гэрээ	8576 988 404 79	✓	✓	✓	✓	✓

恒通集团
Heng Tong Group

Монгол улсын Эрүүл мэндийн сайн гэрээ 2017 оны 12 сарын 12 өдөр А/98 хүчин
Эрүүл мэндийн хөгжлийн үйлдвэр төслийн эрүүл мэндийн үзүүлэлт үнэмлэхийг хянах
хуульчилсан тухай акт
恒通蒙古铜矿项目门诊体检处理登记表

Эмгэгчдийн хөгжлийн бодлогоор урьдчилж үзүүлэх байгууллагад хүргэхэд өгөх бүртгэлийн маягт

Эрүүл мэндийн үйлдвэр төслийн эрүүл мэндийн үзүүлэлт үнэмлэхийг хянах тухай акт

Төрийн эрүүл мэндийн газар: 8576 988 404 79
Харьяат байр, утас: 470000

Эрүүл мэндийн байгууллагын нэр	Харьяат байр, утас	Хүрээлэнгийн эрүүл мэндийн үзүүлэлт үнэмлэхийг хянах	Эрүүл мэндийн үзүүлэлт үнэмлэхийг хянах	Эрүүл мэндийн үзүүлэлт үнэмлэхийг хянах	Хүрээлэнгийн эрүүл мэндийн үзүүлэлт үнэмлэхийг хянах	Хүрээлэнгийн эрүүл мэндийн үзүүлэлт үнэмлэхийг хянах
Монгол улсын Эрүүл мэндийн сайн гэрээ	8576 988 404 79	✓	✓	✓	✓	✓

恒通集团
Heng Tong Group

Монгол улсын Эрүүл мэндийн сайн гэрээ 2017 оны 12 сарын 12 өдөр А/98 хүчин
Эрүүл мэндийн хөгжлийн үйлдвэр төслийн эрүүл мэндийн үзүүлэлт үнэмлэхийг хянах
хуульчилсан тухай акт
恒通蒙古铜矿项目门诊体检处理登记表

Эмгэгчдийн хөгжлийн бодлогоор урьдчилж үзүүлэх байгууллагад хүргэхэд өгөх бүртгэлийн маягт

Эрүүл мэндийн үйлдвэр төслийн эрүүл мэндийн үзүүлэлт үнэмлэхийг хянах тухай акт

Төрийн эрүүл мэндийн газар: 8576 988 404 79
Харьяат байр, утас: 470000

Эрүүл мэндийн байгууллагын нэр	Харьяат байр, утас	Хүрээлэнгийн эрүүл мэндийн үзүүлэлт үнэмлэхийг хянах	Эрүүл мэндийн үзүүлэлт үнэмлэхийг хянах	Эрүүл мэндийн үзүүлэлт үнэмлэхийг хянах	Хүрээлэнгийн эрүүл мэндийн үзүүлэлт үнэмлэхийг хянах	Хүрээлэнгийн эрүүл мэндийн үзүүлэлт үнэмлэхийг хянах
Монгол улсын Эрүүл мэндийн сайн гэрээ	8576 988 404 79	✓	✓	✓	✓	✓

恒通集团
Heng Tong Group

Монгол улсын Эрүүл мэндийн сайн гэрээ 2017 оны 12 сарын 12 өдөр А/98 хүчин
Эрүүл мэндийн хөгжлийн үйлдвэр төслийн эрүүл мэндийн үзүүлэлт үнэмлэхийг хянах
хуульчилсан тухай акт
恒通蒙古铜矿项目门诊体检处理登记表

Эмгэгчдийн хөгжлийн бодлогоор урьдчилж үзүүлэх байгууллагад хүргэхэд өгөх бүртгэлийн маягт

Эрүүл мэндийн үйлдвэр төслийн эрүүл мэндийн үзүүлэлт үнэмлэхийг хянах тухай акт

Төрийн эрүүл мэндийн газар: 8576 988 404 79
Харьяат байр, утас: 470000

Эрүүл мэндийн байгууллагын нэр	Харьяат байр, утас	Хүрээлэнгийн эрүүл мэндийн үзүүлэлт үнэмлэхийг хянах	Эрүүл мэндийн үзүүлэлт үнэмлэхийг хянах	Эрүүл мэндийн үзүүлэлт үнэмлэхийг хянах	Хүрээлэнгийн эрүүл мэндийн үзүүлэлт үнэмлэхийг хянах	Хүрээлэнгийн эрүүл мэндийн үзүүлэлт үнэмлэхийг хянах
Монгол улсын Эрүүл мэндийн сайн гэрээ	8576 988 404 79	✓	✓	✓	✓	✓

Зураг 7-17. Эрүүл мэндийн хог хаягдал устгуулсан тухай акт



БҮЛЭГ 8 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

8.1 ЦАГ УУРЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

Төслийн талбай орших Дорноговь аймаг нь уур амьсгалын хувьд хуурайдуу сэрүүвтэр, хуурай дулаавтар мужид багтах бөгөөд Монгол орны бусад нутгийн нэгэн адил эх газрын эрс тэс уур амьсгалтай. Агаарын температурын үнэмлэхүй их амплитуд 33.6°C , өвөлдөө хүйтэн боловч зундаа аагим халуун байдаг.


Цагаан суваргын төслийн талбайд 2012 онд Campbell брендийн CR-1000 загварын цаг уурын автомат станц суурилуулж, 2013 онд УЦУОШГ-аар баталгаажилт хийлгэсэн байдаг. Тус цаг уурын станц нь 2013 оны 04-р сарын 11-ны хүртэл хэвийн ажиллаж байгаад тэжээлийн эх үүсвэрийн тасалдалын улмаас ажиллагаагүй байсныг 2024 оны 03-р сарын 11-ны өдөр гэрээт байгууллагаар засвар үйлчилгээг хийлгэн, хэвийн үйл ажиллагаанд оруулаад байна. Цаг уурын автомат станц нь дараах иж бүрдлээс бүрдэж байна. Үүнд:

- Салхины чиглэл, хурдны мэдрүүр – RMYOUNG 05103
- Агаарын температур – 109 L
- Агаарын температур, чийгийн мэдрүүр – HMP35V
- Хур тунадасны мэдрүүр – TE525
- Нарны цацрагийн балансийн мэдрүүр – NR-LITE2
- Нарны зайн хавтан - 30W
- Аккумуляторын батарей – 12V
- Даталоггер – CR1000
- Комьпютерт холбох зориулалт бүхий кабель – RS232

Цаг уурын станцыг хувийн үйл ажиллагаанд оруулсны дараа БОМТ-д тусгасны дагуу сар бүр цаг уурын үзүүлэлтүүдийг нэгтгэн дүгнэж байна.

Хүснэгт 8-1. Төслийн дуу шуугианы хяналт мониторингийн цэгүүд

№	Цэгийн нэр	Цэгийн координат	Хяналт мониторингийн ач холбогдол, давтамж
1	CR-1000 цаг уурын станц	49 U 286084 UTM 4861774	Цаг уурын үзүүлэлтүүд буюу салхины чиглэл, хурд, агаарын температур, чийг, хур тунадас, нарны цацраг зэргийг хянах зорилготой 24 цагийн станц бөгөөд сар бүр датаг нэгтгэн авна.



Зураг 8-1. Цаг уурын станцын байршил

Агаарын температур

Төслийн талбайн агаарын температурын хэмжилтийн үр дүнгээс үзэхэд агаарын дундаж температур 3-р сард 3.15°C, 4-р сард 10.97°C, 5-р сард 19.22°C, 6-р сард 23.09°C, 7-р сард 25.84°C, 8-р сард 23.8°C, 9-р сард 16.38°C байсан байна. Цаг уурын станцын сар болон өдрийн дундаж температурын харьцуулалтыг доор тусгав.

Хүснэгт 8-2. Сарын дундаж агаарын температур (C°-ээр)

№	Үзүүлэлт	Сар						
		III	IV	V	VI	VII	VIII	IX
1	T _{max}	10.52	17.63	26.86	29.7	32.23	29.41	22
2	T _{min}	-4.21	4.31	11.58	16.48	19.46	18.19	10.76
3	T _{mean}	3.15	10.97	19.22	23.09	25.84	23.8	16.38








График 8-1. Агаарын дулаан хүйтний сарын явц






График 8-2. Агаарын дулаан хүйтний өдрийн явц

Хур тунадасны горим

Төслийн талбайн ойр орчимд 2024 оны 10-р сарын байдлаар 117.088 мм хур тунадас унасан бөгөөд түүний ихэнх хувь нь дулааны улиралд буюу 7-9 сарын хооронд орсон байна. Сар бүр унасан нийлбэр хур тунадасны хэмжээг доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 8-3. Сарын дундаж агаарын температур (C°-ээр)

№	Үзүүлэлт	Сар						
		III	IV	V	VI	VII	VIII	IX
1	Хур тунадас (мм)	0	0.508	11.94	3.048	35.56	65.53	0.508




График 8-3. Сарын нийлбэр хур тунадасны явц

Агаарын чийгшлийн горим

Агаар усны уураар ханах төлөвтөө хир зэрэг дөхөж байгааг илэрхийлэх үзүүлэлт бол харьцангуй чийгшил юм. Тэгвэл нэгж эзэлхүүнтэй агаарт агуулагдаж буй усны уурын тоо хэмжээг граммаар илэрхийлснийг үнэмлэхүй чийгшил гэнэ. Төслийн талбай орчимд нэн хуурай уур амьсгалтай буюу жилийн дундаж харьцангуй чийгшлийн утга хэлбэлзэл ихтэй, өвлийн улиралд агаар хөрж, улмаар усны уурыг агуулах чадвар буурснаар (агаар шахагдах) ханасан төлөвтөө ойртох учраас харьцангуй чийгшил хамгийн их хэмжээндээ хүрэх ба хавар дулаарснаар (агаар тэлж) агаарын усны уурыг агуулах чадвар нэмэгдээд ирэх үед хамгийн хуурай болох учир харьцангуй чийгшлийн хамгийн бага утга 25-35% болсон байна. Харин зун хур борооны улирал эхлэхээр дахин бага зэрэг нэмэгдээд, намар эргээд буурах хэдий ч хүйтрэлт эхлэхэд агаар шахагдсанаар намрын сүүл сард өссөн байна.

Хүснэгт 8-4. Агаарын чийгшлийн үзүүлэлт (%)

№	Үзүүлэлт	Сар						
		III	IV	V	VI	VII	VIII	IX
1	Харьцангуй чийгшил (RH_{max})	55.15	47.17	41.19	49.96	66.77	72.60	79.11
2	Харьцангуй чийгшил (RH_{min})	14.56	14.94	10.16	14.80	21.60	25.56	31.02
3	Харьцангуй чийгшил (RH_{mean})	34.85	31.05	25.67	32.38	44.18	49.08	55.06

Салхины хурд, чиглэл

Нарны цацраг дэвсгэр гадаргад ирээд зарим хэсэг нь буцаж ойдог бол зарим хэсэг нь түүнд шингэснээр дулааны энергид шилжинэ. Дэвсгэр гадаргын жигд бус байдлаас болоод гадарга мөн харилцан адилгүй халж, улмаар агаарын даралтын жигд бус хуваарилалт бий болно. Даралт ихтэй (хүйтэн) газраас багатай (дулаан) руугаа хэвтээ чиглэлийн дагуу шилжих агаарын урсгалыг салхи гэнэ.

Хүснэгт 8-5. Салхины дундаж хурд (м/с)

№	Үзүүлэлт	Сар						
		III	IV	V	VI	VII	VIII	IX
1	Дундаж салхины хурд, м/с	28.45	32.73	32.89	31.21	26.46	21.69	24.62

Төслийн бүс нутагт тайлант онд зүүн хойд (NE) болон баруун өмнөд (SE) зүгийн салхи хамгийн их давтагдалтай байсан байна.





График 8-4. Салхины чиглэлийн давтагдал (3-9-р сар)

8.2 ДУУ ЧИМЭЭНИЙ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

Хүрээлэн буй орчинд үүсэж буй дуу шуугианы түвшин тодорхой стандарт хэмжээнээс давсан тохиолдолд хүний эрүүл мэндэд болон зэрлэг амьтдад сөргөөр нөлөөлж болзошгүй байдаг тул төслийн талбай болон түүний ойр орчимд хяналт шинжилгээг явуулан ажиллаж байна. 2024 оны БОМТ-ний дагуу 5 цэгт дуу чимээний хэмжилтийг хийж гүйцэтгэлээ.

Хүснэгт 8-6. Төслийн дуу шуугианы хяналт мониторингийн цэгүүд

№	Цэгийн дугаар	Цэгийн нэр	Цэгийн координат	Хяналт мониторингийн ач холбогдол, давтамж
1	SXEW_S_1	Оффис	49 U 288189 UTM 4861652	Дуу чимээнээс үүсэж буй сөрөг нөлөөллийг үнэлэх, арга хэмжээ төлөвлөх, дата мэдээлэл үүсгэх зорилгоор жилд 1 удаа
2	SXEW_S_2	Баяжуулах үйлдвэр	49 U 288100 UTM 4861592	
3	SXEW_S_3	УХЗ-ны хажууд	49 U 288225 UTM 4861553	
4	SXEW_S_4	Нуруулдан уусгах талбайн баруун талд	49 U 287544 UTM 4861271	
5	SXEW_S_6	Дотоод тээврийн замын хажууд	49 U 288032 UTM 4860732	



Зураг 8-2. Дуу чимээний хяналт мониторингийн цэгүүд



Зураг 8-3. Дуу чимээний хэмжилт

Дуу чимээний хэмжилтийг Байгаль орчны төв лаборатороор 5 цэгт хийлгэхэд стандартаас давсан үзүүлэлт илрээгүй.

Хүснэгт 8-7. Дуу чимээний хэмжилтийн үр дүн

№	Цэгийн дугаар	Цэгийн нэр	Дуу чимээ
			ДБА
1	SXEW_S_1	Оффис	53
2	SXEW_S_2	Баяжуулах үйлдвэр	51
3	SXEW_S_3	УХЗ-ны хажууд	50
4	SXEW_S_4	Нуруулдан уусгах талбайн баруун талд	38
5	SXEW_S_6	Дотоод тээврийн замын хажууд	40
MNS4585:2016			60





График 8-5. Дуу чимээний хэмжилтийн үр дүн

8.3 АГААРЫН ЧАНАРЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

Төслийн агаарын чанарын хяналт шинжилгээний ажлыг сөрөг нөлөөлөл үүсгэж болохуйц ажлын талбаруудаас хамаарч агаарын чанарын нийт 6 цэгт орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу агаар дах тоос тоосонцор (TSP, PM₁₀, PM_{2.5}), хүхэрлэг хий (SO₂), азотын давхар ислийн (NO₂) агууламжыг жилийн турш төлөвлөгөөнд тусгагдсан хуваарийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Хүснэгт 8-8. Төслийн агаарын чанарын хяналт мониторингийн цэгүүд

№	Цэгийн дугаар	Цэгийн нэр	Цэгийн координат	Дээж авсан цэгийн тодорхойлолт
1	SWEX_A_1	Оффис	49 U 288184 UTM 4861647	
2	SWEX_A_2	Баяжуулах үйлдвэрийн баруун талд	49 U 288099 UTM 4861588	
3	SWEX_A_6	Нуруулдан уусгах талбайн урд талд	49 U 287988 UTM 4861452	Төслийн үйл ажиллагаанаас агаарын орчинд үүсэж буй сөрөг нөлөөллийг үнэлэх, тоосжилт бууруулах арга хэмжээний хэрэгжилттэй харьцуулах, дата мэдээлэл үүсгэх
4	SWEX_A_8	УХЗ, склад хоёрын дунд	49 U 288221 UTM 4861452	
5	SWEX_A_9	Пүү	49 U 288294 UTM 4861597	
6	SWEX_A_10	Дотоод тээврийн зам дагуу	49 U 287441 UTM 4860971	



Зураг 8-4. Агаарын хяналт мониторингийн цэгүүд



Зураг 8-5. Агаарын чанарын хэмжилт хийх үеийн зураг

Агаарын чанарын үзүүлэлтүүд буюу хүхэрлэг хий, азотын давхар исэл, нийт тоосны агууламжийг Байгаль орчны төв лаборатороор 6 цэгт хийлгэхэд MNS4585:2016 стандартаас давсан үзүүлэлт илрээгүй.

Хүснэгт 8-9. Агаарын чанарын хяналт шинжилгээний үр дүн

№	Цэгийн дугаар	Цэгийн нэр	Хүхэрлэг хий (SO ₂)	Азотын давхар исэл (NO ₂)	Нийт тоосны агууламж (TSP)
			мкг/м ³	мкг/м ³	мкг/м ³
1	SWEX_A_1	Оффис	10	28	156



2	SWEX_A_2	Баяжуулах үйлдвэрийн баруун талд	12	30	93
3	SWEX_A_6	Нуруулдан уусгах талбайн урд талд	14	22	180
4	SWEX_A_8	УХЗ, склад хоёрын дунд	9	34	216
5	SWEX_A_9	Пүү	10	29	78
6	SWEX_A_10	Дотоод тээврийн зам дагуу	11	20	260
MNS4585:2016			450	200	500




График 8-6. Хүхэрлэг хийн хэмжилтийн үр дүн




График 8-7. Азотын давхар ислийн хэмжилтийн үр дүн




График 8-8. Нийт тоосны хэмжилтийн үр дүн


8.4 ХӨРСӨН БҮРХЭВЧИЙН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

Төслийн талбайн хүрээнд аараг толгод бүхий гадарга нь гуу жалгын хэрчигдэл ихтэй нам уулс болон тэдгээрийн хоорондох тэгшивтэр хөндий болон талархаг гадарга, жижиг дов довцог зэрэг гадаргын олон янзын хэлбэрийг хамарч д.т.д 940-960 м өндөрт байрлана. Талбайн хэмжээнд Монгол орны хөрсний ангиллаар Борсаарал хөрсний дэд хэв шинжид багтах чулуурхаг, нимгэн, сайргархаг Борсаарал төрлийн хөрснүүд дангаараа болон бүрдэл байдлаар тархсан байна. Эдгээр хөрс нь ерөнхий үржил шимийн түвшин маш бага, шимт үе давхарга нь нимгэн (0-30 см), хэврэг өрмөнцөр болон үйрмэг бүтэцтэй, механик нөлөөлөлд тэсвэргүй, байгалийн аясаараа нөхөн сэргэх чадамж маш сул байдаг онцлогтой. Мөн маш их чулуурхаг, том ширхэгтэй элсний агууламж өндөртэй байна.

Төслийн үйл ажиллагааны үед хөрсний хими, физикийн шинж чанар, хүнд металлын агууламжид гарч болзошгүй өөрчлөлт, холбогдох стандартыг хангаж буй эсэхийг хянах зорилгоор төлөвлөгөөнд тусгасан цэгүүдэд хуваарийн дагуу хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлээ.

Хүснэгт 8-10. Төслийн хөрсний хяналтын цэгүүд

№	Цэгийн дугаар	Цэгийн нэр	Цэгийн координат	Дээж авсан цэгийн тодорхойлолт
1	SXEW_S_1	Нуруулдан уусгах талбайн баруун урд	49 U 287508 UTM 4861059	
2	SXEW_S_3	Шимт уусмалын сангийн баруун хойно	49 U 287858 UTM 4861721	Төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг үнэлэх, цаашид авах арга хэмжээг төлөвлөх, дата мэдээлэл үүсгэх
3	SXEW_S_4	Баяжуулах үйлдвэрийн баруун талд	49 U 288092 UTM 4861540	
4	SXEW_S_6	УХЗ-ны зүүн хойно	49 U 288221 UTM 4861594	
5	SXEW_S_7	Дотоод тээврийн замын зүүн талд	49 U 288347 UTM 4860704	



Зураг 8-6. Хөрсний хяналт мониторингийн цэгүүд#



Зураг 8-7. Хөрсний дээжлэлт хийх үеийн зураг

Хөрсний үржил шимийн түвшнийг тодорхойлдог голлох үзүүлэлт болох хөрсний ялзмагийн агууламж болон хөрсний хими шинж чанарын үзүүлэлтүүд буюу урвалын орчин(pH), карбонатын агууламж зэргийг тодорхойлсон бөгөөд үзүүлэлт тус бүрийн үр дүнгийн талаар доор дэлгэрэнгүй тайлбарласан болно. Үүнд:

Хөрсний урвалын орчин(pH): Энэ үзүүлэлт нь хөрсний хүчиллэг болон шүлтлэгийг тодорхойлох үзүүлэлт болдог. Хөрсний pH-ээс тухайн хөрсөнд явагдах химийн үйл явцууд шууд болон урвуу хамааралтай байдаг. Хөрсний урвалын орчин 6.6-7.3 саармаг, 7.4-7.8 сул шүлтлэг, 7.9-8.4 дунд зэрэг шүлтлэг, 8.5-9.0 хүчтэй шүлтлэг, >9.0 хэт шүлтлэг гэж үздэг. Ерөнхийдөө хөрсний урвалын орчин сул хүчиллэгээс сул шүлтлэг буюу 5.6-8.4 байхад ургамал ургахад тохиромжтой гэж үздэг. Шинжилгээний үр дүнгээс харахад хөрсний pH-ийн утга 8.5-9.5 буюу дунд зэрэг шүлтлэгээс хэт шүлтлэг урвалын орчинтой, дунджаар 8.7 байгаа нь ургамал ургахад тохиромж багатай байна.

Хөрсний ялзмаг: Хөрсний ялзмаг гэдэг нь ургамал болон амьтны гаралтай үлдэгдэл материалын задралаас хөрсөнд үүсдэг бараан өнгөтэй, эрдэс органикийн нийлмэл бодис юм. Ялзмаг нь өөртөө маш олон төрлийн шим тэжээлийн бодисыг (ялангуяа азотыг) агуулж байдаг учраас хөрсний үржил шимийн хамгийн чухал үзүүлэлт болдог. Ялмагийн бодис нь ойролцоогоор 60% нүүрстөрөгч, 6% азот болон фосфор, хүхэр зэрэг макро микро элементүүдийг өөртөө агуулж байдаг. Ялмагийн бодис их байх тусам хөрсний өнгө гүн хар болдог. Ялмагийн бодисын гол үүрэг ач холбогдол нь хөрсний физик нөхцөлийг сайжруулах, чийгийн багтаамжийг нэмэгдүүлэх, хамгийн сайн бүтэц үүсэхэд нөлөөлөх, усанд уусамтгай үржил шимийн бодисуудыг тогтоон барих, хөрсөн дэх биологи ба микробиологийн идэвхийг сайжруулж ургамлын үндэсний хөгжилтийг дэмжих, хөрсөн дотор явагдах химийн урвалуудад буфер (зохицуулагч)-ийн үүрэг гүйцэтгэх, хөрсөн дэх организмын хүнс болон энергийн эх үүсвэр болох, хөрсний агаар солилцоог сайжруулах зэрэг олон талын ач холбогдолтой байдаг. Хөрсийг ялмагийн агууламжаар нь <1% маш бага, 1-2% бага үнэлдэг. 6-р сар болон 9-р сарын шинжилгээний үр дүнгээс харахад хөрсний ялмагийн агууламж 0.65-3.06% байгаа нь тайлант онд чийгийн хангамж сайтай байсантай холбоотой.

Хөрсний хөдөлгөөнт кали, фосфор: Хөрсний кали, фосфор нь ургамлын шим тэжээлийн хамгийн чухал анхдагч макро элементүүд бөгөөд эдгээрээс нэг нь л дутагдахад ургамал ургах боломжгүй болдог. Фосфор (P) нь ургамлын эрүүл өсөлтөд шаардлагатай олон тооны чиг үүрэг гүйцэтгэж, бүтцийн чадавх, ургацын чанар, үрийн гарц зэрэгт илүү хувь нэмэр оруулдаг. Хөрсөн дэх фосфорын пентоксид (P₂O₅) нь ургамалд хамгийн хялбар ашиглагддаг. Фосфорыг агууламжаар нь 1-2мг/100г бага, 2-3мг/100г дунд зэрэг хангамжтай гэж үнэлдэг. Кали нь ихэвчлэн "чанарын элемент" гэж нэрлэгддэг бөгөөд ургамлын чанар, хэмжээ, хэлбэр, өнгө, амт гэх мэт олон шинж чанаруудад нөлөөлдөг. Хөрсөн дэх калийн исэл (K₂O) нь ургамалд хамгийн хялбар ашиглагддаг. Калийг агууламжаар нь 5-10 мг/100г бага, 10-15 мг/100г дунд зэрэг, 15-20 мг/100г сайн, 20-30 мг/100г маш сайн хангамжтай гэж үнэлдэг. Шинжилгээний үр дүнгээс харахад бүх хөрснүүдийн өнгөн үе давхаргад хөдөлгөөнт фосфорын хангамж 1.2-2.04 мг/кг байгаа нь сайн хангамжтай байна.

Хүснэгт 8-11. 6-р сарын хөрсний шинжилгээний харуу

№	Цэгийн дугаар	Цэгийн нэр	pH	Чийг %	Нитратын азот (NO ₃)	Сульфат (SO ₄)	Фосфор мг/кг	Амиакийн азот	Ялзмаг
1	SXEW_S_1	Нуруулдан уусгах талбайн баруун үрд	9.16	0.34	10.201	36.2	1.02	767.00	1.55
2	SXEW_S_3	Шимт уусмалын сангийн баруун хойно	9.54	0.80	19.392	25.7	1.16	73.83	2.09
3	SXEW_S_4	Баяжуулах үйлдвэрийн баруун талд	8.67	0.96	15.45	203.1	2.04	39.38	0.65
4	SXEW_S_6	УХЗ-ны зүүн хойно	9.50	1.12	5.959	19.8	1.89	66.45	0.90
5	SXEW_S_7	Дотоод тээврийн замын зүүн талд	9.58	1.80	7.956	37.7	1.62	348.77	3.06

8.5 УСАН ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

Цагаан суваргын катодын зэсийн үйлдвэр төслийн 2024 оны БОМТ-ний усан орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт дараах ажлууд тусгагдсаны дагуу хийж гүйцэтгэн ажиллалаа. Үүнд:

Дотоод хяналт шинжилгээний хөтөлбөр:

- Технологийн 5 хяналтын цооногийн статистик түвшний хэмжилт

Хөндлөнгийн хяналт шинжилгээний хөтөлбөр


- Төслийн талбайн 3 унд ахуйн усны физик, химийн үндсэн үзүүлэлтүүдийн шинжилгээ

Унд ахуйн усан хангамж

Төслийн талбайн унд ахуйн усны эх үүсвэрүүдээс дээж авч, ерөнхий хими физикийн шинжилгээг хуваарийн дагуу байгаль орчны төв лаборатороор хийлгэлээ.

Хүснэгт 8-12. Төслийн унд ахуйн усны цэгүүд

№	Цэгийн дугаар	Цэгийн нэр	Цэгийн координат	Дээж авсан цэгийн тодорхойлолт
1	TS_WQ_1	Унд ахуйн худаг	49 U 294303 UTM 4875252	Төслийн талбайд ажиллаж буй ажилчдын унд ахуйн усан хангамжийн цэгүүд бөгөөд усны чанарыг үнэлэх, дата мэдээлэл үүсгэхэд ач холбогдолтой.
2	TS_WQ_2	Унд ахуйн ус (Гал тогоо)	49 U 286506 UTM 4861800	
3	TS_WQ_5	Унд ахуйн ус (цэвэршүүлсэн)	49 U 286465 UTM 4862428	



Зураг 8-8. Төслийн унд ахуйн усны хяналт мониторингийн цэгүүд

Усны хими, физикийн шинжилгээний үр дүнгээс үзэхэд MNS 0900:2018. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан үзүүлэлт илрээгүй байна.

Хүснэгт 8-13. Усны хими, физикийн үзүүлэлтүүд

№	Цэгийн дугаар	Усны орчин (pH)	EC	Ca	Mg	NaK	SO ₄	Cl	HCO ₃	NH ₄	NO ₂	NO ₃	PO ₄	F	Fe
1	TS_WQ_1	8.18	1814	13.35	5.35	355	198	229	287	0.05	0.003	3.41	0.004	3.39	0.01
2	TS_WQ_2	8.12	1884	4.45	9	362	206	239	268	0.08	0.009	3.43	0.005	3.38	0.04

3	TS_WQ_5	8.07	1887	11.86	3.65	368	214	226	293	0.06	0.008	3.45	0.005	3.40	0.03
MNS900:2018		6.5-8.5	-	100	30	-	500	350	-	1.5	1	50	3.5	0.7-1.5	0.3




График 8-9. Усны шинжилгээний үр дүн

Хяналтын цооногууд – Төслийн талбайн ойролцоо орших 5 хяналтын цооногийн статик түвшинг орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хянан ажиллаж байна.

Хүснэгт 8-14. Нарангийн хоолойн хяналтын цооногууд

№	Цэгийн дугаар	Цэгийн нэр	Цэгийн координат	Дээж авсан цэгийн тодорхойлолт
1	SWEX_GW_1	Төслийн талбайн зүүн хойно 2.5км	49 U 290063 UTM 4862697	Төслийн үйл ажиллагаа газрын доорх усан орчинд хэрхэн нөлөөлж буй талаар үнэлэх, цаашдын төлөвлөгөөнд ашиглах
2	SWEX_GW_2	Төслийн талбайн зүүн хойно 1.7км	49 U 289995 UTM 4862113	



Зураг 8-9. Нарангийн хоолойн хяналтын цооногууд

Хүснэгт 8-15. Цооногуудын статистик түвшний хэмжилтийн үр дүн

№	Цэгийн дугаар	Цэгийн нэр	Усны статистик түвшин (м)
1	SWEX_GW_1	Төслийн талбайн зүүн хойно 2.5км	2.45
2	SWEX_GW_2	Төслийн талбайн зүүн хойно 1.7км	6.43
3	SWEX_GW_3	Төслийн талбайн зүүн хойно 1.67км	7.7
4	SWEX_GW_4	Төслийн талбайн зүүн хойно 1.5км	6.75
5	SWEX_GW_5	Төслийн талбайн зүүн хойно 1.6км	13.63

8.6 УРГАМЛАН НӨМРӨГИЙН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ


Төслийн талбайн ургамлын аймаг, ургамалжилтын судалгааг 8-р сард буюу ургамлын вегетацийн хугацаанд орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан 4 цэгт ургамалжилтын бичиглэл үйлдсэн.

Хүснэгт 8-16. Төслийн хөрсний хяналт мониторингийн цэгүүд

№	Цэгийн дугаар	Цэгийн нэр	Цэгийн координат	Дээж авсан цэгийн тодорхойлолт
---	---------------	------------	------------------	--------------------------------





1	SXEW_P_1	Нуруулдан уусгах талбайн баруун талд	49 U 287518 UTM 4861225
2	SXEW_P_2	Нуруулдан уусгах талбайн баруун хойно	49 U 287777 UTM 4861584
3	SXEW_P_3	Шимт уусмалын сангийн баруун хойно	49 U 287882 UTM 4861817
4	SXEW_P_4	Баяжуулах үйлдвэрийн хойно	49 U 288141 UTM 4861758
5	SXEW_P_5	Нуруулдан уусгах талбайн зүүн талд	49 U 288558 UTM 4861220

Төслийн үйл ажиллагаанаас ургамалд үзүүлж буй сөрөг нөлөөллийг үнэлэх, төслийн талбайн ойр орчмын ургамалжилтыг бүртгэж дата мэдээлэл үүсгэх ач холбогдолтой.



Зураг 8-10. Ургамлын хяналт мониторингийн цэгүүд


Хүснэгт 8-17. Ургамлын судалгааны үеийн зураг

№	Цэгийн дугаар	Цэгийн нэр	Ургамалжилтын зураг
1	SXEW_P_1	Нуруулдан уусгах талбайн баруун талд	
2	SXEW_P_2	Нуруулдан уусгах талбайн баруун хойно	
3	SXEW_P_3	Шимт уусмалын сангийн баруун хойно	
4	SXEW_P_4	Баяжуулах үйлдвэрийн хойно	

5


SXEW_P_5

Нуруулдан уусгах талбайн зүүн талд



Зураг 8-11. Ургамлын хяналт мониторингийн үеийн зураг

Төслийн талбайн нь Монгол орны ургамал газарзүйн мужлалаар төслийн талбай нь Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрогт буюу Дорноговь аймгийн Мандах сумын нутагт оршино.



Зураг 8-12. Монгол орны ургамал газарзүйн тойрог

Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрог: Говь-Алтайн нурууны зүүн шувтаргын уулсын араар, Олон нуурын тойргоос (Онгийн голын зүүн талын дэнжээс) дорно зүгт ухаа гүвээрхэг, тэгш гадаргатай уужим талархаг газар хамаарна. Хойгуураа Дундад Халх, зүүн хойгуураа Дорнод Монголын тойрогтой хил залгана. Энэ тойрог далайн түвшнээс дээш 850-1,400 м-т орших бөгөөд дунджаар 1,100-1,200 м өндөр юм. Тойргийн баруун өмнөд хэсэгт Говь-Алтайн нурууны захын салбар уулс (Тахилга уул, Ихшанхай, Хавчиг, Ханбогд уул), баруун хойд хэсэгт Дэлгэрхангай уул бий. Тойргийн баруун урд захаас зүүн хойд хэсэг хүртэл тухайлбал: Галбын говиос зүүн хойш Зүүнбаянгын уудам хотгор үргэлжилнэ. Ихэнхдээ элсэн манхтай. Энэ тойрогт давс, марцтай хотгорууд бий. Харин тогтмол устай гол байхгүй.

Ургамлын аймаг

Төслийн талбай ойр орчимд 29 овгийн 77 төрөлд хамаарагдах 105 зүйл ургамал бүртгэгдсэн.

Тэдгээрийг ангилал зүйн нэгжээр нь салгаж үзвэл далд үртийн хүрээний нэг талт үрт ургамлын ангийн 4 овгийн 8 төрлийн 21 зүйл ургамал бүртгэгдсэн ба түүнээс хамгийн их зүйлтэй нь үетэн 14 зүйл, сарааны овог 4 зүйл, улалж 1 зүйл болон цахилдгийн овог 2 зүйл тус тус байна.




График 8-10. Нэг талт үрт ургамлын ангийн төлөөлөгчид

Хос үрийн талт ургамлын ангийн 25 овгийн 60 төрлийн 85 зүйл ургамал тэмдэглэгдсэнээс хамгийн их зүйлтэй нь луулийн овог 19 зүйл, нийлмэл цэцэгтийн овог 17 зүйл, буурцагтан 10 зүйл, хотирын овог 5 зүйл, ноцоргонын овог 4 зүйл, уруул цэцэгтэн, тарнын овог, тоонолжтон тус бүр 3 зүйл болон үлдсэн овгууд нь тус бүр 1-2 зүйлтэй байна.




График 8-11. Хос талт үрт ургамлын ангийн төлөөлөгчид

Төслийн талбайн ургамлын зүйлийн бүрдлийг зонхилох овгуудын эзлэх хувиар нь авч үзлээ. Энд луулийн овог 16 %, нийлмэл цэцэгтийн овог 15 %, үетэн 12 %, буурцагтан 9 % болон 1-5 зүйлтэй бусад овгууд 48 %-ийг тус тус эзэлж байна.




График 8-12. Төслийн талбайн зүйлийн бүрдэлд зонхилох овгууд

Тодорхойлогдсон нийт ургамлын зүйлүүдийг амьдралын хэлбэрийн хувьд ангилж үзвэл олон наст өвслөг ургамал 64 %, нэг наст өвслөг ургамал 11 %, мод 3 %, паразит 2 %, сөөг 9 % болон заримдаг сөөг 11 % байлаа.




График 8-13. Амьдралын хэлбэрийн ангилал

Экологийн бүлгийн хувьд авч үзвэл ксерофит-хуурайсаг ургамлын зүйлүүд 43 %, мезоксерофит-чийгсүү-хуурайсаг ургамлын зүйлүүд 24 %, петрофит-чулуусаг ургамлын зүйлүүд 19 %, псаммофит-элссэг ургамлын зүйлүүд 7 %, галофит-давссаг ургамлын зүйлүүд 3 %, ксерогигрофит-хуурайсаг-чийгсүү болон мезофит чийгсүү ургамлын зүйлүүд тус бүр 2 % бүртгэгдсэн байна.





График 8-14. Экологийн бүлгийн ангилал

Үүнээс үзэхэд тухайн төслийн талбай болон түүний ойр орчмын нутаг дэвсгэрт хуурайсаг, чулуусаг ургамлын зүйлүүд зонхилон тархсан нь гадаргын хэв шинжийг чулуурхаг жижиг аараг толгод бүрдүүлж байгааг болон элссэг, давссаг зүйлүүд цөөнгүй тохиолдож байгаа нь давсархаг хотгор, толгодын ёроолоор хуримтлалын элс байгааг баталж байгаа хэрэг юм.

8.7 АМЬТНЫ АЙМГИЙН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлж буй сөрөг нөлөөллийг үнэлэх, төслийн талбайн ойр орчмын амьтны үзэгдлийг бүртгэж урт хугацааны дата мэдээлэл үүсгэх зорилгоор төслийн талбайн ойр орчимд орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хяналт шинжилгээ хийж байна.



Зураг 8-13. Хулан, хар сүүлт, цагаан зээрийн тархалт

Дорноговь аймгийн төв хэсэг буюу Мандах, Хөвсгөл сумдын нутаг дэвсгэрт орших бүсэд хялгана-хазаар өвст, хялгана-алаг өвст, хялгана-жижиг дэгнүүлт үетэнт, Монгол өвс-шавагт, монгол өвс-хазаар өвс-таанат, лууль сөөгтэй шарилж-монгол өвст, монгол өвс-боролзот, монгол өвс-таанат, монгол өвс-таана-агьт, монгол өвс-бударгана, тэсэг-боролзой-шарилжид ургамлын нөмрөгт бүлгэмдлийг шүтэн амьдардаг хар сүүлт зээр, цагаан зээр, хулан адуу, аргаль хонь, бор туулай, шар чичүүл, морин чичүүл, сибирь алагдаага, говийн алагдаага, говийн гүрвэл, толбот хонин гүрвэл, монгол гүрвэл, нохой гүрвэл, зэрэг хөхтөн, хоёр нутагтан мөлхөгчдийг дагасан саарал чоно, шар үнэг, хярс үнэг, шилүүс, халздай дорго, суусар булга зэрэг махчид тохиолдохыг өмнөх судалгааны тайлан, ном бүтээлд тусгажээ (Дорноговь аймгийн биологийн баялаг, 2004).

Амьтны аймгийн хяналт шинжилгээг төслийн талбайг бүрэн хамруулж хийсэн.

Хөхтөн

Хээрийн ажиглалтын үед адууны овгоос хулан адуу, тугалмайтны овгоос хар сүүлт, цагаан зээр, туулайн овгоос бор туулай, зарааны овгоос дагуур зараа зэргийг бүртгэлээ. Төслийн талбай орчимд ажиглагдсан хөхтөн амьтад мөн амьдрах орчны хувьд тохиромжтой, байх боломжит амьтдын хамгааллын зэрэглэлийг Олон улсын байгаль хамгаалах холбоо (IUCN)-ны шалгуур үзүүлэлтүүдээр харуулав.

Хүснэгт 8-18. Орчны хяналт шинжилгээний үед бүртгэгдсэн хөхтөн амьтдын зүйлийн жагсаалт

№	Шинжлэх ухааны нэр	Монгол нэр	Бүс нутгийн үнэлгээ	Олон улсын үнэлгээ
Зарааны овог- Erinaceidae				
1	<i>Hemiechinus auritus</i>	Дэлдэн зараа	АӨ	АӨ
Туулайн овог- Leporidae				
1	<i>Lepus tolai</i>	Бор туулай	АӨ	АӨ
Адууны овог- Equidae				
1	<i>Equus hemionus</i>	Монгол хулан	Эмзэг	УБ
Тугалмайтны овог- Bovidae				

1	<i>Gazella subgutturosa</i>	Хар сүүлт зээр	Эмзэг	Эмзэг
2	<i>Procarpa gutturosa</i>	Цагаан зээр	АӨ	УБ
3	<i>Ovis ammon</i>	Аргаль хонь		



Зураг 8-14. Орчны хяналт шинжилгээний үед бүртгэгдсэн хөхтөн амьтад

Мөлхөгчид

Хээрийн ажиглалтын үед угалзат могойн овгоос сум могой, замба гүрвэлийн овгоос цоохор хонин гүрвэл бүртгэгдсэн. Тэдгээрийг доорх хүснэгтэд Дэлхийн байгаль хамгаалах холбооны шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд бүх зүйл бүс нутгийн болоод Олон улсын хэмжээнд “Анхааралд өртөхөөргүй” буюу тоо толгой нь хэвийн байна.

Хүснэгт 8-19. Орчны хяналт шинжилгээний үед бүртгэгдсэн мөлхөгчидийн зүйлийн жагсаалт

№	Салбар баг	Овог	Зүйл	Бүс нутгийн үнэлгээ 2006	Олон улсын үнэлгээ 2021
1	Могойн салбар баг (Serpentes)	Угалзат могойн овог (Colubridae)	Сум могой (<i>Psammophis lineolatus</i>)	АӨ	АӨ
2	Гүрвэлийн салбар баг (Lacertilia)	Замба гүрвэлийн овог (Agamidae)	Цоохор хонин гүрвэл (<i>Phrynocephalus versicolor</i>)	АӨ	АӨ



Зураг 8-15. Орчны хяналт шинжилгээний үед бүртгэгдсэн мөлхөгчид

Шувууд

Хээрийн ажиглалтын үед шувуудаас нөмрөг тас, хон хэрээ, хээрийн бүргэд зэргийг бүртгэлээ.

Хүснэгт 8-20. Орчны хяналт шинжилгээний үед бүртгэгдсэн шувуудын зүйлийн жагсаалт

№	Зүйлийн жагсаалт	Бүс нутгийн үнэлгээ	ОУ-ын үнэлгээ	CITES	Экологийн статус
1	Хон хэрээ	АӨ	АӨ		Суурин зүйл
2	Нөмрөг тас	АӨ	Эмзэг	II	Суурин, зөвхөн залуу шувуу нүүдэг
3	Хээрийн бүргэд	АӨ	АӨ	II	Суурин зүйл
4	Тураг гогой	АӨ	АӨ		Нүүдлийн





Зураг 8-16. Хээрийн судалгааны үед бүртгэгдсэн шувууд



БҮЛЭГ 9 УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

МАК Аранжин Зэс ХХК-ийн Дорноговь аймгийн Мандах сумын нутагт орших Цагаан суваргын зэс-молибдены ордыг ашиглах төслийн явцад байгаль хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгахтай холбоотой арга хэмжээг тухай бүрд авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд байгаль орчны мэргэжилтэн нь төслийн БОМТөлөвлөгөөг хэрэгжүүлэх, удирдлагад танилцуулж шийдвэрлэх, орон нутгийн иргэд болон төрийн захиргааны байгууллагад танилцуулах, тайлагнах 6 арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүллээ.

Хүснэгт 9-1. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Хэрэгжилт
1	Төслийн үйл ажиллагаанд шаардагдах байгаль орчны холбогдолтой дүрэм, журам, зааварыг боловсруулах, Монголын Алт (МАК) ХХК-ийн батлагдсан дүрэм журмыг төслийн талбайн ажилчид болон гэрээт байгууллагуудад танилцуулах, мөрдүүлэх	Төслийн үйл ажиллагааны хүрээнд Монголын Алт (МАК) ХХК-ийн Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан дараах байгаль орчны журмуудыг дагаж мөрдөн ажиллаж байна. <ul style="list-style-type: none">• Хог хаягдлын менежментийн журам• Орчны хяналт шинжилгээний журам• Усны менежментийн журам• Газрын бүртгэлийн журам Түүнчлэн үндсэн ажилчид болон гэрээт байгууллагын ажилчдад дээрх журмуудыг таниулах сургалтуудыг тогтмол зохион байгуулсан. 2024 онд үндсэн 32 ажилтан, гэрээт байгууллагуудын 46 ажилтайн сургалтад хамрагдсан байна. (Дэлгэрэнгүйг 6.1-с үзнэ үү.)
2	Ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол оруулах. Ажилчдыг ажлын онцлогоос хамааруулан хувь хүний хамгаалалтын хэрэгслээр тогтмол хангах	МАК Аранжин Зэс ХХК нь эрүүл мэндийн даатгалын дагуу нийт ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамруулан ажиллаж байна. Тайлант онд нийт 24 ажилтан шинээр даатгалд хамрагдаад байна. Түүнчлэн төслийн талбайд ажиллаж буй ажилчдыг ажлын байрны онцлогт нь тохирсон нэг бүрийн хамгаалах хэрэгслээр ханган ажиллаж байна. (Дэлгэрэнгүйг 6.2-с үзнэ үү.)
3	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг орон нутгийн иргэдтэй хамтран хэрэгжүүлэх	Төслийн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ нөлөөллийн бүсэд байрлах орон нутгийн иргэдтэй хамтран дээж цуглуулах, шинжилгээний хариуг тайлагнах зэргээр хамтын оролцоотой хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Тайлант онд нөлөөллийн бүсийн иргэн Ч.Бямба-Эрдэнэтэй хамтран орчны хяналт шинжилгээг хийлээ. (Дэлгэрэнгүйг 6.3-с үзнэ үү.)
4	Цагаан суваргын зэс-молибдены ордыг ашиглах төсөлтэй хамтран Мандах сумын ахлах ангийн ЕБСийн сурагчдад хог хаягдалын менежментийн талаар сургалт таниулах үйл ажиллагаа явуулах	2024 оны БОМТ-г бүрэн хэрэгжүүлж журмын дагуу 11-р сарын 01-ээс өмнө байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд тайлагнаж байна.
5	Мандах сумын ахлах ангийн ЕБСийн сурагчдад хог хаягдлын менежментийн талаар сургалт таниулах үйл ажиллагаа явуулах	Төсөл хэрэгжиж буй аймаг, сумын ард иргэдийн байгаль орчны мэдлэгийг нэмэгдүүлэх, иргэдтэй хамтран хамгааллын үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор 2024 онд Мандах сумын ЕБС-ын сурагчдад хог хаягдлын менежментийн

6 Төслийн талбайн гэрээт байгууллагуудад байгаль орчны чиглэлээр сургалт оруулах

тухай сургалтыг орж, сургуулийн орчинд хэрхэн хог хаягдлаа бууруулах боломжийг хамтран судаллаа. (Дэлгэрэнгүйг 6.4-с үзнэ үү.)


Төслийн талбайд үйл ажиллагаа явуулж буй гэрээт байгууллагуудын ажилчдад компанийн байгаль орчны чиглэлээр баримталж буй журам дүрмүүдийг танилцуулах зорилгоор жилийн турш сургалтыг орж байна. 2024 онд гэрээт байгууллагуудын 46 ажилтайн сургалтад хамрагдсан байна. (Дэлгэрэнгүйг 6.5-с үзнэ үү.)


9.1 БАЙГАЛЬ ОРЧНЫ ХОЛБОГДОЛТОЙ ЖУРМУУД

Төслийн үйл ажиллагааны хүрээнд Монголын Алт (МАК) ХХК-ийн Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан дараах байгаль орчны журмуудыг дагаж мөрдөн ажиллаж байна.

- Хог хаягдлын менежментийн журам
- Орчны хяналт шинжилгээний журам
- Усны менежментийн журам
- Газрын бүртгэлийн журам

Түүнчлэн үндсэн ажилчид болон гэрээт байгууллагын ажилчдад дээрх журмуудыг таниулах сургалтуудыг тогтмол зохион байгуулсан. 2024 онд үндсэн 32 ажилтан, гэрээт байгууллагуудын 46 ажилтайн сургалтад хамрагдсан байна.





Зураг 9-1. Байгаль орчны холбогдолтой мөрдөгдөж буй журмууд

9.2 АЖИЛЧДЫН ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДАЛ

МАК Аранжин Зэс ХХК нь эрүүл мэндийн даатгалын дагуу нийт ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамруулан ажиллаж байна. Тайлант онд нийт 32 ажилтан шинээр даатгалд хамрагдаад байна. Түүнчлэн төслийн талбай дээр анхан тусламжийн төв ажиллаж, яаралтай үед ажилчдын эрүүл мэндийг хамгаалан ажиллаж байна.

Түүнчлэн төслийн талбайд ажиллаж буй ажилчдыг ажлын байрны онцлогт нь тохирсон нэг бүрийн хамгаалах хэрэгслээр ханган ажиллаж байна.

9.3 ХАМТЫН ОРОЛЦООТОЙ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Төслийн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ нөлөөллийн бүсэд байрлах орон нутгийн иргэдтэй хамтран дээж цуглуулах, шинжилгээний хариуг тайлагнах зэргээр хамтын оролцоотой хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Тайлант онд нөлөөллийн бүсийн иргэн Ч.Бямба-Эрдэнэтэй хамтран орчны хяналт шинжилгээг хийлээ.







Зураг 9-2. Нөлөөллийн бүсийн иргэн дээж авч буй зураг

9.4 СУРАГЧДАД ЗОРИУЛСАН СУРГАЛТ

Төсөл хэрэгжиж буй аймаг, сумын ард иргэдийн байгаль орчны мэдлэгийг нэмэгдүүлэх, иргэдтэй хамтран хамгааллын үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор 2024 онд Мандах сумын ЕБС-ын сурагчдад хог хаягдлын менежментийн тухай сургалтыг орж, сургуулийн орчинд хэрхэн хог хаягдлаа бууруулах боломжийг хамтран судаллаа.



Зураг 9-3. ЕБС-ын сурагчдад зориулсан сургалтын үеийн зураг



Зураг 9-4. Сурагчдын хөгжлийн үзлийн холбоотой санаачилга

9.5 БАЙГАЛЬ ОРЧНЫ СУРГАЛТ

Төслийн талбайд үйл ажиллагаа явуулж буй гэрээт байгууллагуудын ажилчдад компанийн байгаль орчны чиглэлээр баримталж буй журам дүрмүүдийг танилцуулах зорилгоор жилийн турш сургалтыг орж байна. 2024 онд гэрээт байгууллагуудын 46 ажилтайн сургалтад хамрагдсан байна.



Зураг 9-5. Гэрээт ажилчдын байгаль орчны сургалт

ХАВСРАЛТ

№	Хавсралт	Хуудас
1	Ус ашиглуулах дүгнэлт	5
2	Ус ашиглах гэрээ	5
3	Усны тоолуурын баталгаажуулалтын гэрчилгээ	5
4	Усны тоолуур суурилуулсан тухай акт	8
5	Ус ашигласны төлбөр төлсөн тухай баримт	1
6	Хаягдал усны дүгнэлт	3
7	Ус бохирдуулсны төлбөр төлсөн тухай баримт	1
8	Мандах сумтай байгуулсан энгийн хог хаягдлын гэрээ	2
9	Төвшин сайхан мөнх НҮТББ-тай байгуулсан дахивар хог хаягдал нийлүүлэх гэрээ	4
10	Түмэн эгшиг ХХК-тай байгуулсан аюултай хог хаягдлын гэрээ	1
11	Эмнэлгийн тусгай хаягдлыг устгуулах гэрээ	2
12	Аюултай хог хаягдлын Ү дугаар	1
13	Аюултай хог хаягдал устгуулсан тухай акт	1
14	Эрүүл мэндийн хог хаягдал устгуулсан тухай акт	1
15	Агаарын чанарын хяналт шинжилгээний үр дүн	5
16	Хөрсөн бүрхэвчийн хяналт шинжилгээний үр дүн	1
17	Усны лабораторийн шинжилгээний үр дүн	2



БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ
**ГАЛБА-ӨӨШ-ДОЛООДЫН ГОВИЙН
САВ ГАЗРЫН ЗАХИРГАА**

305 тоот, Соёмбо цогцолбор, 3 дугаар баг,
Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103
Утас/факс: (976) 7052 3681,
Цахим шуудан: Galba.usgz@gmail.com

2024.05.28 № 90

танай 2024.05.15-ны № 01/68 -Т

“ЭРДЭНЭС ЦАГААН СУВАРГА”
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Г.ЦОГТ ТАНАА

Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4-т заасны дагуу Дорноговь аймгийн Мандах сумын нутагт хэрэгжиж буй “Цагаан суваргын зэс-молбидений ордыг ашиглах” төсөлд 2024 оны ус ашиглуулах дүгнэлтийг гарган хавсралтаар хүргүүллээ.

Хувийг; Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт

Хавсралт / хуудастай

ДАРГА  БЯЛАЛТБАЯР



2240145

**ГАЛБА-ӨӨШ-ДОЛООДЫН ГОВИЙН САВ ГАЗРЫН ЗАХИРГАА
УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ**

2024 оны 05-р сарын
28-ны өдөр

Дугаар-01

Сайншанд сум

1. Аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, хаяг, утас факс, улсын бүртгэлийн дугаар

“Эрдэнэс цагаан суварга” ХХК-ийн гүйцэтгэх захирал Г.Цогт, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 1-р хороо, 19-р хороолол, чингисийн өргөн чөлөө, Монголын алт ХХК-ийн байр. Утас 70107482. Улсын бүртгэлийн дугаар - 9011465103, регистрийн дугаар-5824826.

2. Төслийн нэр, байршил

Дорноговь аймаг, Мандах сум, Алхан тээг багийн нутагт байрладаг. Галба-Өөш-Долоодын говийн сав газарт харьяалагдана.

3. Төсөл хэрэгжүүлэгч

“Эрдэнэс цагаан суварга” ХХК

4. Тусгай зөвшөөрлийн дугаар болон талбайн координат /X,Y/:

Сэрвэн сухайт МҮ-009630А.

108° 20' 20" 43° 51' 30"

108° 20' 20" 43° 52' 00"

108° 21' 00" 43° 52' 00"

108° 21' 00" 43° 52' 20"

108° 21' 30" 43° 52' 20"

108° 21' 30" 43° 51' 56"

108° 21' 00" 43° 51' 56"

108° 21' 00" 43° 51' 30" 132 га талбай.

5. Үйлдвэрлэл, үйлчилгээний нэр төрөл, зориулалт:

Зэс-молбиденийг олборлох баяжуулах үйлдвэр.

6. Үйлдвэрийн техник, технологи /ажиллах горим, хүчин чадал/:

Зэс-молбидений баяжуулах үйлдвэрийн барилга угсралтын ажлыг 360 хоног ажиллана. Баяжуулах үйлдвэр ашиглалтад орсноор жилд 14.6 сая.тн хүдэр олборлож, баяжуулахаар төлөвлөсөн.

7. Үйлдвэрлэх, боловсруулах бүтээгдэхүүний хэмжээ:

Тус ордын үйлдвэрлэлийн нийт 247 сая.тн сульфидын хүдрийг ил аргаар, гадаад овоолготой, авто тээвэртэй ашиглалтын системээр жилд 14.6 сая.тн хүдэр олборлох хүчин чадалтайгаар 20 жил ашиглахаар төлөвлөсөн. 2024 газар шорооны ажлыг бүрэн дуусгаж нийт барилга угсралтын үйл явц 100%-д хүрнэ.

8. Усны эх үүсвэр, нөөц, чанар, хоногт ашиглах хэмжээ /шоо.метрээр/:

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2011 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн А/69 тушаалаар Дорноговь аймгийн Мандах сумын Нарангийн хоолойн ГДУ-ны ордын ашиглалтын нийт нөөцийг 220 л/секундээр баталсан.

Усны газрын 2023 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 119 дугаартай усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлтийг гаргуулсан.
2024 онд хоногт ашиглах ус 96.67 м3/хон байна.

9. Усны барилга байгууламжууд /нэр, хүчин чадал, барилга, байгууламжийн хэмжээ хийц/:

Нарангийн хоолойн газрын доорх усны ордоос шугам сүлжээ татна.

10. Худаг, өргөлтийн станцууд, усны тоолуур /насосны хүчин чадал, марк/:

Нарангийн хоолойн газрын доорх усны ордоос 2024 онд ашиглалт явуулахгүй. Баяжуулах үйлдвэрийн барилга угсралтын ажил болон унд ахуйн хэрэглээнд өөрийн эзэмшлийн 2 худгийг ашиглана

Худгийн нэр	Солбицол	Гүн, м	Ундарга л/сек	Гаргасан он	Усны тоолуур
Худаг - 1	108 26 2.12, 44 00 4.14	97	13.3	2013	Тоолууртай
Худаг - 2	108 26 44.5 44 00 19.0	100	10.0	2013	Тоолууртай

11. Дамжуулах байгууламж /шугам сүлжээний урт, диаметр/:

Дамжуулах байгууламж, шугам сүлжээний талаарх мэдээлэл тодорхойгүй.

12. Хаягдал бохир усны хэмжээ, цэвэрлэгээний арга, түвшин:

Бохирын систем Хятадын WSZ-A-6 маркийн 6м³/ц хүчин чадалтай саарал ус гаргах цэвэрлэх төхөөрөмж суурилуулсан. Уг төхөөрөмжийн өмнөх дамжлагад өтгөн тунаах зориулалтай 4ш 50тн цуваа байрлалтай ёмкост суурилуулсан. WSZ-A-6 маркийн цэвэрлэх төхөөрөмж нь үндсэн 4 хэсгээс бүрдэнэ. Үүнд хүчилтөрөгчтэй орчинд амьдрах чадвартай бактери бүхий 2ш сав, неон гэрэл бүхий 1ш сав, дээж авах зориулалтай бүхий 1ш сав эдгээрээс бүрдэнэ. Мөн хүчилтөрөгч өгөх зориулалт бүхий 2 ш компрессор байна. Сүүлийн дамжлагаас гарсан саарал ус нь ус хуримтлуулах усан санд орно. Хоногт 150 м3 ус цэвэрлэх хүчин чадалтай.

13. Байгаль орчны үнэлгээ, нөхцөл

Цагаан суваргын зэс-молбидений ордыг ашиглах байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тодотголыг 2023 онд "Баялаг эко" ХХК хийж гүйцэтгэсэн.

14. Онцгой нөхцөл:

Улирал бүр 2-оос доошгүй удаа хаягдал усны холимог сорьц авч, байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэж, хариуг улирал бүрийн сүүлийн сарын 15-ны дотор ирүүлэх шаардлагатайг анхаарах.

15. Холбогдох хууль, дүрэм, журам, норм, стандарт, баримт бичгийн дагуу усны зарцуулалтыг тооцох

БОНХАХЖ-ын сайдын 2015 оны А/301 "Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм батлах тухай" тушаалын дагуу тооцоход:

Унд ахуйд - 470хүн*150л *365 хон=**25732.5** м³/жил

Бетон зуурмаг үйлдвэрлэхэд 30000м³ * 0,3 м³ = **9000.0** м³/жил

Ногоон байгууламжийн усалгаа- 8,592м²*2л*32удаа =**549.9** м³/жил

16. Холбогдох хууль, тогтоол шийдвэрийн дагуу оногдуулах усны нөөцийн

төлбөрийн хэмжээ:

Ногоон байгууламжийн усалгаанд ашиглах усны төлбөрийн хэмжээг Засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоолоор Галба-Өөш-Долоодын говийн сав газарт тогтоосон усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ, Засгийн газрын 2013 оны 327 дугаар тогтоолд заасан ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр, Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолд заасан усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг ашиглан тооцсон болно.

Төлбөр тооцоход:

Ногоон байгууламжийн усалгаанд усны нөөц ашигласны төлбөр:

$$1 \text{ м}^3 \text{ газрын доорх усны үнэ: } 3,996.0 \text{ төг/м}^3 \times 0.1 \times 0.18 = 71.928 \text{ төг/м}^3$$

- 3,996.0 төг Галба-Өөш-Долоодын говийн сав газарт газрын доорх ус ашигласан нөхцөлд тогтоосон экологи, эдийн засгийн суурь үнэлгээ

- 0.1 (10%) Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын дагуу газрын доорх усны нөөц ашигласны төлбөрийн 9-д заасан хувь хэмжээ

- 0.18 Засгийн газрын 2013 оны 327 дугаар тогтоолын дагуу ашигт нөхөн сэргээлт, ногоон байгууламжийн усалгааны зориулалтаар газар доорх ус ашигласан нөхцөлд тооцох ашиглалтын зориулалтын итгэлцүүр

$$549.9 \text{ м}^3 \times 71.928 \text{ төг/м}^3 = 39,553.0 \text{ төгрөг}$$

Бетон зуурмагийн үйлдвэрлэлд усны нөөц ашигласны төлбөр:

$$1 \text{ м}^3 \text{ газрын доорх усны үнэ: } 3,996.0 \text{ төг/м}^3 \times 0.2 \times 0.25 = 199.8 \text{ төг/м}^3$$

- 3,996.0 төг Галба-Өөш-Долоодын говийн сав газарт газрын доорх ус ашигласан нөхцөлд тогтоосон экологи, эдийн засгийн суурь үнэлгээ

- 0.2 (20%) Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын дагуу газрын доорх усны нөөц ашигласны төлбөрийн 3-д заасан хувь хэмжээ

- 0.25 Засгийн газрын 2013 оны 327 дугаар тогтоолын дагуу барилгын материалын үйлдвэрлэл буюу бетон зуурмаг үйлдвэрлэх зориулалтаар газар доорх ус ашигласан нөхцөлд тооцох ашиглалтын зориулалтын итгэлцүүр

$$9000 \text{ м}^3 \times 199.8 \text{ төг/м}^3 = 1,798,200.0 \text{ төгрөг}$$

Ашиг олох зориулалтаар газрын доорх усны нөөц ашигласны төлбөр:

$$1 \text{ м}^3 \text{ газрын доорх усны үнэ: } 3,996.0 \text{ төг/м}^3 \times 0.15 \times 0.16 = 95.9 \text{ төг/м}^3$$

- 3,996.0 төг Галба-Өөш-Долоодын говийн сав газарт газрын доорх ус ашигласан нөхцөлд тогтоосон экологи, эдийн засгийн суурь үнэлгээ

- 0.15 (15%) Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын дагуу газрын доорх усны нөөц ашигласны төлбөрийн 10-д заасан хувь хэмжээ

- 0.26 Засгийн газрын 2013 оны 327 дугаар тогтоолын дагуу ашиг олох зориулалтаар газар доорх ус ашигласан нөхцөлд тооцох ашиглалтын зориулалтын итгэлцүүр

$$25732.5 \text{ м}^3 \times 95.9 \text{ төг/м}^3 = 2,467,747.0 \text{ төгрөг}$$

Нийт төлбөр: $39,553.0 + 1,798,200.0 + 2,467,747.0 = 4,305,500.0$ төгрөг

/Дөрвөн сая гурван зуун таван мянга таван зуун төгрөг/

17. Үйлдвэрлэл, үйлчилгээнд усны нөөцийг хэмнэх, эргүүлж ашиглах даалгавар:

Ахуйн бохир усыг цэвэрлэн, халдваргүйжүүлж стандартын шаардлагад нийцүүлэн ногоон байгууламжийн усалгаанд ашиглах.

18. Тавих шаардлага, цаашид авах арга хэмжээ, зөвлөмж:

- “Усны тухай” хуулийн 28.6, 29.1-дэх заалтуудыг тус тус үндэслэн Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас ус ашиглах зөвшөөрөл авч, гэрээ байгуулах;
- Хуулийн 31.2-т зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөрийг 50

хүртэл хувиар өсгөн тооцож төлөхөөр заасныг анхаарч, жил бүрийн ажлын төлөвлөгөөг үндэслэлтэй гаргаж байх;

- Ахуйн болон үйлдвэрлэлийн хэрэглээнээс гарсан хаягдал усыг хүрээлэн байгаа орчинд нийлүүлэхэд "Хаягдал ус. Ерөнхий шаардлага" MNS 4943:2015 стандартыг мөрдөж ажиллах;
- Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны А-156 тушаалаар баталсан Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журмын хэрэгжилтийг хангаж ажиллах;
- Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Барилга, хот байгуулалтын сайдын 2015 оны А-230/127 хамтарсан тушаалаар батлагдсан Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөн ажиллах;
- Хаягдал усны дүгнэлтийг тухайн жилийн эхний улиралд багтаан гаргуулах
- Ус ашиглалтын тайланг 2024 оны 11-р сарын 30-нд багтаан ирүүлэх;
- Усны нөөцийг хомстох бохирдохоос хамгаалж хяналт шинжилгээг тогтмол хийлгэж байх;
- Нарангийн хоолойн газрын доорх усны ордод ашиглаж буй мониторингийн цэгийн тасралтгүй үйл ажиллагааг хангах зорилгоор засвар үйлчилгээг тогтмол хийх;
- Баяжуулах үйлдвэр болон уулын ажил эхэлсэн тохиолдолд ашиглах усны хэмжээ өөрчлөгдөх тул ус ашиглуулах дүгнэлтийг шинэчилж гаргуулах;

БАТАЛГААЖУУЛСАН:
ДАРГА



Б.ЯЛАЛТБАЯР

ДҮГНЭЛТ ГАРГАСАН:
ГАЗРЫН ДООРХ УСНЫ НӨӨЦ,
АШИГЛАЛТЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Э.УНДРАХГЭРЭЛ



**ДОРНОГОВЬ АЙМАГ
БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103
Утас: (976) 7052 2663, факс: (02-522) 4-27-26
Цахим шуудан: Dgaboajg@do.mne.gov.mn
Цахим хаяг: www.do.mine.gov.mn

2024.06.04 № 252

танай _____-ны № _____-т

**“ЭРДЭНЭС ЦАГААН СУВАРГА” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Г.ЦОГТ ТАНАА**

Танай 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 01/74 тоот албан бичиг, Галба-Өөш, Долоодын говийн сав газрын захиргааны 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 90 тоот албан бичиг, ус ашиглуулах 01 тоот дүгнэлтийг үндэслэн 2024 оны ус ашиглах зөвшөөрлийг гарган гэрээг батлан хавсралтаар хүргүүлээ.

Хавсралтхуудастай.

Хувийг Аймгийн Татварын хэлтэс, Мандах сумын Засаг даргын тамгын газарт

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



С.ЭНХЗОРИГ

4424030306

БАТЛАВ:
Байгаль орчин, аялал жуулчлалын
газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч:
гүйцэтгэх захирал

[Signature]
/С.ЭНХЗОРИГ/



УС АШИГЛАХ ГЭРЭЭ

2024 оны 06 дугаар сарын 04-ний өдөр

Дугаар 12

Сайншанд сум



“Эрдэнэс цагаан суварга”
ХХК-ийн гүйцэтгэх захирал

[Signature]
/Г.ЦОГТ/

Нэг. Ерөнхий зүйл

Усны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.4 дахь заалт, 28 дугаар зүйлийн 28.4, 28.6, 28.7 дахь заалт, 29 дүгээр зүйлийн 29.1-д заасны дагуу “Галба-өөш Долоодын говийн сав газрын захиргаа”-ны 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 01 тоот ус ашиглуулах дүгнэлтийг үндэслэн:

Ус ашиглуулагчийг төлөөлж Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Усны нөөц, ашиглалт, хамгаалалт хариуцсан мэргэжилтэн Ширнэн овогтой Амгалансайхан, Ус ашиглагчийг төлөөлж Дорноговь аймгийн Мандах сумын нутагт байрлах улсын бүртгэлийн дугаар 9011465103 тоот гэрчилгээ, 5824826 тоот регистрийн дугаартай “Эрдэнэс цагаан суварга” ХХК-ний Усны инженер Эрдэнэбат овогтой Жамц нар ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг 1 жилийн хугацаатайгаар байгуулав.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1. Ус ашиглах зориулалт: Үйлдвэрийн үйл ажиллагаа болон хүн амын унд ахуйн хэрэгцээнд усны нөөцийг ашиглана.

2.2. Ашиглах усны хэмжээ:

2.2.1. унд-ахуйд 25732.5 м³/жил/

2.2.2. Бетон зуурмаг үйлдвэрлэхэд 9000.0 м³/жил/

2.2.3. Ногоон байгууламжийн усалгаа 549.9 м³/жил/

2.3. Усны чанар, найрлага:

2.4. Усны эх үүсвэр болон байршил: Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2011 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн А/69 тоот тушаалаар Дорноговь аймгийн Мандах сумын Нарангийн хоолойн ГДУ-ны ордын ашиглалтын нийт нөөцийг 220 л/секундээр баталсан. Усны газрын 2023 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 119 дугаартай усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлтийг гаргуулсан. 2024 онд хоногт ашиглах ус 96,67 м³/хон байна.

Усны барилга байгууламжууд /нэр, хүчин чадал, барилга, байгууламжийн хэмжээ, хийц/:

Тоног төхөөрөмжийн нэр, марк:

Нарангийн хоолойн ГДУ-ны ордоос шугам сүлжээ татна. 2023 онд ашиглалт явуулахгүй. Баяжуулах үйлдвэрийн барилга угсралтын ажил болон унд ахуйн хэрэглээнд өөрийн эзэмшлийн 1 худгийг ашиглана.

2.5. Хаягдал усны хэмжээ: Бохирын систем Хятад улсын WSZ-G-6 маркийн 6м³/ц хүчин чадалтай саарал ус гаргах цэвэрлэх төхөөрөмж суурилуулсан. Уг төхөөрөмжийн өмнөх

097-5124

МОНГОЛЫН АЛТ
УС АШИГЛАХ ХХК

дамжлагад өтгөн тунгаах зориулалттай 4ш 50тн цуваа байрлалтай ёткост суурилуулсан. WSZ-G-6 маркийн цэвэрлэх төхөөрөмж нь үндсэн 4 хэсгээс бүрдэнэ. Үүнд хүчилтөрөгчтэй амьдрах чадвартай бактери бүхий 2 ш сав неон гэрэл бүхий 1ш сав, дээж авах зориулалт бүхий 1 ш сав эдгээрээс бүрдэнэ. Мөн хүчил төрөгч өгөх зориулалт бүхий 2ш компрессор байна. Сүүлийн дамжлагаас гарсан саарал ус нь ус хуримтлуулах усан санд орно. Хоногт 150 м³ ус цэвэрлэх хүчин чадалтай. 25732.5 м³/жил/

2.6. Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ: Хаягдал бохир уснаас улирал тутам дээж авч усны биохимийн шинжилгээний дүнг тухай бүрт нь Байгаль орчин, аялал жуулчлалын газарт ирүүлнэ. 1.5 кг/м³

Жинлэгдэх бодис, кг.....

Органик бодис, кг.....

Эрдэс бодис, кг.....

Хүнд металл, кг.....

Аюултай бохирдуулах бодис, гр.....

2.7. Бохир ус цэвэрлэх барилга байгууламжийн байршил, хүчин чадал, технологи, цэвэрлэх арга, цэвэрлэгээний түвшин: Ахуйн хэрэглээний ус, технологийн процессын хэсгүүдээс гарах бүх усыг хаягдлын санруу зайлуулна.

2.8. Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох, бохирдохоос сэргийлэх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээг төлөвлөж ирүүлнэ.

2.9. Усны тоолуур:

Худгийн нэр	Солбицол	Гүн,м	Ундрага л/сек	Гаргасан он	Усны тоолуур
Худаг	108 26 2.12, 44 00 4.14	97	13,3	2013	Тоолуургүй

Төрөл, нэр, дугаар:

2.10. Ус ашигласны нэгж төлбөрийн хэмжээ:

Дүгнэлт 16-д заасны дагуу нийт 35282.4 м³ /жил усны нөөцийн төлбөр 4305500,0 төг /дөрвөн сая гурван зуун таван мянга таван зуун төгрөг/

2.11. Хаягдал усан дахь нэгж бохирдуулах бодист ногдох төлбөрийн хэмжээ:

Гурав. Талуудын эрх, үүрэг

Гэрээ байгуулагч талууд Усны тухай хуулийн 7.5, 10.1.18, 13.1.1, 13.1.5, 18.1.4, 19.1.2, 19.1.4, 26.1, 30.1, 30.2, 31.1-д заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

Дөрөв. Бусад

4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл, хаягдал усны талаарх дүгнэлт, хаягдал ус зайлуулах зөвшөөрөл, шинжилгээний үзүүлэлт, тоолууржуулалт, экологийн паспорт хөтлөх /MNS 4219-94/ Засгийн газрын тогтоол, төлбөр тооцох аргачлал нь гэрээний салшгүй хэсэг байна.

4.3. Гэрээний 2.3, 2.4, 2.6, 2.7, 2.8, 2.9 дахь заалтуудад заагдсан чанар, найрлага, байршил, бохирдуулах бодисын хэмжээ, хаягдал ус хаях цэгийн байршил, усны эх үүсвэрүүдийн тоолууржуулалт, ус хамгаалах арга хэмжээний талаарх мэдээллийг тусгайлан гаргаж Байгаль орчин, аялал жуулчлалын газарт ирүүлнэ.

4.4. Ус ашиглуулагч нь тухайн жилийн 11 дүгээр сарын 01-ний дотор ус ашиглалтын тайлан болон усны нөөц ашигласны төлбөрийн мэдээг хүлээн авч гэрээний биелэлтийг дүгнэж, тэмдэглэл үйлдэнэ.

4.5. Талуудын тохиролцсоноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.

4.6. Гэрээг Усны тухай хуулийн 17.1.9, 29.3 дахь заалтууд болон дор дурдсан үндэслэлээр хугацаанаас нь өмнө цуцалж болно.

4.6.1. ашиглаж байгаа усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн;

4.6.2 аль нэг тал татан буугдсан бол.

4.7. Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Ус ашиглуулагчийг төлөөлж:

Байгаль орчин, аялал жуулчлалын
газрын усны нөөц ашиглалт, хамгаалалт
хариуцсан
мэргэжилтэн...../Ш.Амгалансайхан/

Хаяг: Дорноговь аймаг, Сайншанд хот,
Төрийн өмчийн 3-р байр, 2 давхарт 206 тоот
Харилцах утас: 70522663, 90990887

Ус ашиглагчийг төлөөлж:

“Эрдэнэс цагаан суварга”ХХК-ийн
Усны инженер
/Э.Жамц/

Хаяг: Дорноговь аймаг,
Мандах сум
Харилцах утас: 88997699

НЭХЭМЖЛЭХ

ДТД: 000003312763000240528000001882003

Нэхэмжлэгч:

ТТД: 3312763

НЭР: ГАЛБА-ӨӨШ, ДОЛООДЫН ГОВИЙН САВ ГАЗРЫН
ЗАХИРГАА

Хаяг: Монгол, Дорноговь, Сайншанд, 2-р баг, энхтайван, 1-р
цэцэлэгийн байр

Утас:

Э-Шуудан: tuyanaa3232@gmail.com

Банкны нэр: Төрийн сан

Банкны дансны дугаар: 100060013002

Хариуцагч:

ТТД: 5824826

НЭР: ЭРДЭНЭС ЦАГААН СУВАРГА

Хаяг: Монгол, Улаанбаатар, Хан-Уул, 1-р хороо,
чингисийн өргөн чөлөө, төв байр 44 тоот

Утас: 70107482

Гэрээний №:

Огноо: 2024-05-28

Төлбөр хийх хугацаа(Хоног):

Д/д	Бараа, ажил, үйлчилгээний нэр	Код	Хэмжих нэгж	Тоо, хэмжээ	Нэгжийн үнэ	Бүгд үнэ
1	төрийн байгууллагаас үзүүлж байгаа үйлчилгээ	412	ш	1	100,000.00	100,000.00

Бараа, ажил үйлчилгээний үнэ:	100,000.00
Нэмэгдсэн өртгийн албан татвар:	0.00
Нийслэл хотын албан татвар:	0.00
Нийт дүн:	100,000.00



Мөнгөн дүн:

(үсгээр)

(Тамга)

Захирал:.....

Нягтлан бодогч:.....





СТАНДАРТ,
ХЭМЖИЛ ЗҮЙН
ГАЗАР

УСНЫ ТООЛУУРЫН
БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ
№ ЭУ 087229

.....-Д
(хэрэглэгчийн нэр)
ашиглаж байгаа LXL загварын 63 м³/ц
хэмжих хязгаартай, 80 мм-ийн голчтой № 2023 04 143 -ын
халуун, хүйтэн усны тоолуурыг № 017 лацаар битүүмжилж
(доогуур зурах)
..... 2023 оны 05 -р сарын 14 -ны өдөр хүртэл улсын
баталгаажуулалтын гэрчилгээ олгов.

Шалгалтын дараах заалт: 000002 М³

Лабораторийн тэмдэг

Улсын шалгагчийн
гарын үсэг, тэмдэг

..... 2023 оны 05 -р сарын 14 -ны өдөр



СТАНДАРТ,
ХЭМЖИЛ ЗҮЙН
ГАЗАР

УСНЫ ТООЛУУРЫН
БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ
№ ЭУ ...075288...

.....-Д
(хэрэглэгчийн нэр)
ашиглаж байгаа *LPIC-50* загварын *2.5* м³/ц
хэмжих хязгаартай, ...*50*... мм-ийн голчтой № *202303929* -ын
халуун, хүйтэн усны тоолуурыг № *014* лацаар битүүмжилж
(доогуур зурах)
..... *2025* оны *04* -р сарын *10* -ны өдөр хүртэл улсын
баталгаажуулалтын гэрчилгээ олгов.



Лабораторийн тэмдэг

Шалгалтын дараах заалт: *000002* м³

[Signature]

Улсын шалгагчийн
гарын үсэг, тэмдэг

2023 оны *04* -р сарын *10* -ны өдөр



СТАНДАРТ,
ХЭМЖИЛ ЗҮЙН
ГАЗАР

УСНЫ ТООЛУУРЫН
БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ

№ ЭУ 075284

.....-Д
(хэрэглэгчийн нэр)
ашиглаж байгаа LPLC-50 загварын L5 м³/ц
хэмжих хязгаартай, 50 мм-ийн голчтой № 2023 04023 -ын
халуун, хүйтэн усны тоолуурыг № 014 лацаар битүүмжилж
(доогуур зурах)
..... 2025 оны 04 -р сарын 10 -ны өдөр хүртэл улсын
баталгаажуулалтын гэрчилгээ олгов.

Шалгалтын дараах заалт: 000002 м³



Лабораторийн тэмдэг

..... 2023 оны 04 -р сарын 10 -ны өдөр

.....
Улсын шалгагчийн
гарын үсэг, тэмдэг



СТАНДАРТ,
ХЭМЖИЛ ЗҮЙН
ГАЗАР

УСНЫ ТООЛУУРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ

№ ЭУ ...075286...

.....-Д
(хэрэглэгчийн нэр)
ашиглаж байгаа *LPCC-50* загварын *25* м³/ц
хэмжих хязгаартай, *50* мм-ийн голчтой № *201304084* -ын
халуун, хүйтэн усны тоолуурыг № *014* лацаар битүүмжилж
(доогуур зурах)
..... *2025* оны *04* -р сарын *10* -ны өдөр хүртэл улсын
баталгаажуулалтын гэрчилгээ олгов.

Шалгалтын дараах заалт: *000002* м³



Лабораторийн тэмдэг

[Signature]

Улсын шалгагчийн
гарын үсэг, тэмдэг

2023 оны *04* -р сарын *10* -ны өдөр



СТАНДАРТ,
ХЭМЖИЛ ЗҮЙН
ГАЗАР

УСНЫ ТООЛУУРЫН
БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ
№ ЭУ087230.....

.....-Д
(хэрэглэгчийн нэр)
ашиглаж байгаа *LXLC* загварын *63 м³/ч* м³/ц
хэмжих хязгаартай, *80* мм-ийн голчтой № *202304156*-ын
халуун, хүйтэн усны тоолуурыг № *017* лацаар битүүмжилж
(доогуур зурах)
..... оны *05*-р сарын *24*-ны өдөр хүртэл улсын
баталгаажуулалтын гэрчилгээ олгов.

Шалгалтын дараах заалт: *00000-2* м³

Лабораторийн тэмдэг



..... оны *05*-р сарын *24*-ны өдөр



Улсын шалгагчийн
гарын үсэг, тэмдэг

УСНЫ ТООЛУУР СУУРИЛУУЛСАН
ТУХАЙ АКТ

2024 оны ⁰³ дугаар сарын ²¹ өдөр

№1

Дорноговь аймгийн Алхانتээг сумын 1-р багийн нутагт байрлах “Эрдэнэс Цагаан Суварга” ХХК-ий “Нарангийн хоолойд” байрлах усан хангамжийн эх үүсвэрт 2024-03-21 өдөр тоолуур суулгаж баталгаажуулав.

БНХАУ-д улсад үйлдвэрлэсэн LXLC загварын цагт 63 мЗ/ц хэмжих хязгаартай, 80мм-ийн голчтой тоолуурыг Х 44°20'05,9" У 108°26'03,6 солбицол, Н 901 өндөрлөгт байрлах ЭЦ-09-21 дугаартай эх үүсвэр /худаг, цооног, труба/ суурилуулсан бөгөөд тус компани нь унд ахуй, үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглана.

Тоолуур нь Стандарт, хэмжил зүйн газрын 2023 оны 05 дугаар сарын 24 өдөр баталгаажуулсан 087230 дугаар бүхий гэрчилгээтэй, 63мЗ/цагт хэмжих хязгаартай, 80мм-ийн голчтой №202304156 -ын хүйтэн усны тоолуур 009681 тоолуурын заалттай байлаа.

Тоолуурыг суурилуулж усыг шахаж үзэж шалгахад 009682 гэсэн заалт байсан бөгөөд ус шахах явцад усны тоолуур хэвийн ажиллаж байсан. Усны тоолуурын баталгааны лац нь 017 дугаартай байна.

Усны тоолуурыг суурилуулж холболтыг хянаж байхын тулд 001545 дугаартай лацыг тавьж Мандах сумын Засаг даргын орлогч дарга Б.Бат-Эрдэнэ танилцуулж, Гидрогеологич инженер Э.Жамц нарт хариуцуулсан болно.

ТООЛУУР СУУРИЛУУЛЖ АКТ ҮЙЛДСЭН
МАНДАХ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ОРЛОГЧ
“ЭРДЭНЭС ЦАГААН СУВАРГА” ХХК –ИЙ
УСНЫ ИНЖЕНЕР



Б.БАТ-ЭРДЭНЭ
Э.ЖАМЦ

УСНЫ ТООЛУУР СУУРИЛУУЛСАН
ТУХАЙ АКТ

2024 оны...⁰³ дугаар сарын...²¹ өдөр

№1

Дорноговь аймгийн Алхантаг сумын 1-р багийн нутагт байрлах “Эрдэнэс Цагаан Суварга” ХХК-ий “Нарангийн хоолойд” байрлах усан хангамжийн эх үүсвэрт ²⁰²⁴⁻⁰³⁻²¹ өдөр тоолуур суулгаж баталгаажуулав.

БНХАУ-д улсад үйлдвэрлэсэн LXLC загварын цагт 63 м3/ц хэмжих хязгаартай, 80мм-ийн голчтой тоолуурыг Х ^{44°20'05,9"} у ^{108°26'03,6} солбицол, Н-⁹⁰¹ өндөрлөгт байрлах ЭЦ-09-21 дугаартай эх үүсвэр /худаг, цооног, труба/ суурилуулсан бөгөөд тус компани нь унд ахуй, үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглана.

Тоолуур нь Стандарт, хэмжил зүйн газрын 2023 оны 05 дугаар сарын 24 өдөр баталгаажуулсан 087230 дугаар бүхий гэрчилгээтэй, 63м3/цагт хэмжих хязгаартай, 80мм-ийн голчтой №202304156 -ын хүйтэн усны тоолуур ⁰⁰⁹⁶⁸¹ тоолуурын заалттай байлаа.

Тоолуурыг суурилуулж усыг шахаж үзэж шалгахад ⁰⁰⁹⁶⁸¹ гэсэн заалт байсан бөгөөд ус шахах явцад усны тоолуур хэвийн ажиллаж байсан. Усны тоолуурын баталгааны лац нь 017 дугаартай байна.

Усны тоолуурыг суурилуулж холболтыг хянаж байхын тулд ^{0.01545} дугаартай лацыг тавьж Мандах сумын Засаг даргын орлогч дарга Б.Бат-Эрдэнэ танилцуулж, Гидрогеологич инженер Э.Жамц нарт хариуцуулсан болно.


ТОЛУУР СУУРИЛУУЛЖ АКТ ҮЙЛДСЭН
МАНДАХ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ОРЛОГЧ
“ЭРДЭНЭС ЦАГААН СУВАРГА” ХХК –ИЙ
УСНЫ ИНЖЕНЕР



Б.БАТ-ЭРДЭНЭ

Э.ЖАМЦ


Нарангийн хөдөө
АУ-09-21 дууар тай дууар
2024-03-21 өдөр
Учки 100 мур-н эхний заагт - "9682"



ISO 4064
SQMETERS
Leading Water's Value

01091682 m³

LXLC
DN 80
Q₃ = 63 m³/h
R80; T50
H: V
MAP16
Δp25





СТАНДАРТ,
ХЭМЖИЛ ЗҮЙН
ГАЗАР

УСНЫ ТООЛУУРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ

№ ЭУ 087230

.....-Д
(хэрэглэгчийн нэр)
ашиглаж байгаа 2XLC загварын 63 м³/ч м³/ц
хэмжих хязгаартай, 80 мм-ийн голчтой № 202304156 -ын
халуун, хүйтэн усны тоолуурыг № 017 лацаар битүүмжилж
(доогуур зурах)
..... 2023 оны 05 -р сарын 24 -ны өдөр хүртэл улсын
баталгаажуулалтын гэрчилгээ олгов.

Шалгалтын дараах заалт: 000003 м³

Лабораторийн тэмдэг

..... 2023 оны 05 -р сарын 24 -ны өдөр

Улсын шалгагчийн
гарын үсэг, тэмдэг

УСНЫ ТООЛУУР СУУРИЛУУЛСАН
ТУХАЙ АКТ

2024 оны 03 дугаар сарын 21 өдөр

№2

Дорноговь аймгийн Алхантаг сумын 1-р багийн нутагт байрлах "Эрдэнэс Цагаан Суварга" ХХК-ий "Нарангийн хоолойд" байрлах усан хангамжийн эх үүсвэрт 2024-03-21 өдөр тоолуур суулгаж баталгаажуулав.

БНХАУ-д улсад үйлдвэрлэсэн ЛХС загварын цагт 63 мЗ/ц хэмжих хязгаартай, 80мм-ийн голчтой тоолуурыг Х. 44°00'19,1" У. 108°26'44,6" солбицол, Н-885 өндөрлөгт байрлах 21-09-16 дугаартай эх үүсвэр худаг, цооног, труба/ суурилуулсан бөгөөд тус компани нь унд ахуй, үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглана.

Тоолуур нь Стандарт, хэмжил зүйн газрын 2023 оны 05 дугаар сарын 24 өдөр баталгаажуулсан 087229 дугаар бүхий гэрчилгээтэй, 63мЗ/цагт хэмжих хязгаартай, 80мм-ийн голчтой №202304143 -ын хүйтэн усны тоолуур 060050 тоолуурын заалттай байлаа.

Тоолуурыг суурилуулж усыг шахаж үзэж шалгахад 000051 гэсэн заалт байсан бөгөөд ус шахах явцад усны тоолуур хэвийн ажиллаж байсан. Усны тоолуурын баталгааны лац нь дугаартай байна.

Усны тоолуурыг суурилуулж холболтыг хянаж байхын тулд 001535 дугаартай лацыг тавьж Мандах сумын Засаг даргын орлогч дарга Б.Бат-Эрдэнэ танилцуулж, Гидрогеологич инженер Э.Жамц нарт хариуцуулсан болно.

Усны тоолуур суурилуулж акт үйлдсэн
МАНДАХ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ОРЛОГЧ
"ЭРДЭНЭС ЦАГААН СУВАРГА" ХХК-ИЙ
УСНЫ ИНЖЕНЕР



Б.БАТ-ЭРДЭНЭ

Э.ЖАМЦ

УСНЫ ТООЛУУР СУУРИЛУУЛСАН
ТУХАЙ АКТ

2024 оны 03 дугаар сарын 21 өдөр

№2

Дорноговь аймгийн Алхантаг сумын 1-р багийн нутагт байрлах "Эрдэнэс Цагаан Суварга" ХХК-ий "Нарангийн хоолойд" байрлах усан хангамжийн эх үүсвэрт 2024-08-21 өдөр тоолуур суулгаж баталгаажуулав.

БНХАУ-д улсад үйлдвэрлэсэн LXLС загварын цагт 6.3 м3/ц хэмжих хязгаартай, 80мм-ийн голчтой тоолуурыг Х 44°00'19,1" у 108°26'44,6 солбицол, Н-885 өндөрлөгт байрлах ЭЦ-09-21 дугаартай эх үүсвэр /худаг, цооног, труба/ суурилуулсан бөгөөд тус компани нь унд ахуй, үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглана.

Тоолуур нь Стандарт, хэмжил зүйн газрын 2023 оны 05 дугаар сарын 24 өдөр баталгаажуулсан 087229 дугаар бүхий гэрчилгээтэй, 63 м3/цагт хэмжих хязгаартай, 80мм-ийн голчтой №202304143 -ын хүйтэн усны тоолуур 000050 тоолуурын заалттай байлаа.

Тоолуурыг суурилуулж усыг шахаж үзэж шалгахад 000051 гэсэн заалт байсан бөгөөд ус шахах явцад усны тоолуур хэвийн ажиллаж байсан. Усны тоолуурын баталгааны лац нь дугаартай байна.

Усны тоолуурыг суурилуулж холболтыг хянаж байхын тулд 001535 дугаартай лацыг тавьж Мандах сумын Засаг даргын орлогч дарга Б.Бат-Эрдэнэ танилцуулж, Гидрогеологич инженер Э.Жамц нарт хариуцуулсан болно.


ТООЛУУР СУУРИЛУУЛЖ АКТ ҮЙЛДСЭН
МАНДАХ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ОРЛОГЧ
"ЭРДЭНЭС ЦАГААН СУВАРГА" ХХК - ИЙ
УСНЫ ИНЖЕНЕР



Б.БАТ-ЭРДЭНЭ


Э.ЖАМЦ

Хоргоомын хоолом
ИУ-09-16 гугаарт дугаг
2024-03-21-огор
Усны хэмжээг хянах зориулалт - 000051



LXLC
DN 80
 $Q_3 = 63 \text{ m}^3/\text{h}$
R80; T50
H; V
MAP16
 $\Delta p 25$

000051 m³





СТАНДАРТ,
ХЭМЖИЛ ЗҮЙН
ГАЗАР

УСНЫ ТООЛУУРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ № ЭУ 087229

.....-Д
 (хэрэглэгчийн нэр)
 ашиглаж байгаа захварын м³/ц
 хэмжих хязгаартай, 80 мм-ийн голчтой № 2023 04143 -ЫН
 халуун, хүйтэн усны тоолуурыг № 017 лацаар битүүмжилж
 (доогуур зурах)
 2023 оны 05 -р сарын 24 -ны өдөр хүртэл улсын
 баталгаажуулалтын гэрчилгээ олгов.

Шалгалтын дараах заалт: 000002 м³

Лабораторийн тэмдэг


2023 оны 05 -р сарын 24 -ны өдөр

Улсын шалгагчийн
гарын үсэг, тэмдэг

Хүсэлтийн лавлах дугаар: GB155927202410241

Татсан огноо: 2024-10-24 14:42

Шилжүүлэгчийн дансны дугаар	Хүлээн авагчийн данс	Гүйлгээний дүн	Гүйлгээний төлөв
8140000215 MN750015008140000215	1165117377 MN030015001165117377	4,305,500.00 MNT	Амжилттай
Шилжүүлэгчийн нэр ЭРДЭНЭС ЦАГААНСУВАРГА ХХК	Хүлээн авагчийн нэр МТА.ТАТВАР	Гүйлгээний утга 3240107164906;64101408182;5824826;64101408 182;9802	
	Хүлээн авагчийн банк Голомт банк	Гүйлгээний огноо 2024-10-24	





БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ
**ГАЛБА-ӨӨШ-ДОЛООДЫН ГОВИЙН
САВ ГАЗРЫН ЗАХИРГАА**

305 тоот, Соёмбо цогцолбор, 3 дугаар баг,

Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103

Утас/факс: (976) 7052 3681,

Цахим шуудан: Galba.usgz@gmail.com

2024.09.04

№ 147

танай _____-ны № _____-т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН МАНДАХ
СУМЫН ЗАСАГ ДАРГА Б.УГТАХБАЯР ТАНАА

“Эрдэнэс цагаан суварга” ХХК-ийн 2023 оны
хаягдал усны дүгнэлтийг хавсралтаар хүргүүллээ.

Хувийг: “Эрдэнэс цагаан суварга” ХХК-д

Хавсралт: .2. хуудастай.

ДАРГА



Б.ЯЛАЛТБАЯР

**ГАЛБА-ӨӨШ-ДОЛООДЫН ГОВИЙН САВ ГАЗРЫН ЗАХИРГАА
ХАЯГДАЛ УСНЫ ДҮГНЭЛТ**

2024 оны 09 дугаар
сарын 04-ний өдөр

Дугаар:2024/16

Сайншанд сум

1. Иргэн, аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, хаяг, утас, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар, цахим хаяг

“Эрдэнэс цагаан суварга” ХХК-ийн гүйцэтгэх захирал Г.Цогт, холбоо барих утасны дугаар: 99219059, 70107482, Улсын бүртгэлийн дугаар: 9011465103, Регистрийн дугаар: 5824826

2. Төслийн нэр, байршил

“Эрдэнэс цагаан суварга” ХХК-ийн цагаан суваргын зэс молибдены ордыг ашиглах төсөл нь Дорноговь аймаг, Мандах сумын нутагт байрладаг. Галба-Өөш-Долоодын говийн сав газарт хамаарч байна.

3. Хаягдал ус хаях цэгийн байршил, координат

Унд ахуйн хэрэглээнээс гарсан хаягдал усыг биологийн аргаар цэвэрлэн шүүрүүлэх талбайд нийлүүлдэг.

4. Цэвэрлэгээний арга, түвшин

Бохирын систем Хятадын WSZ-A-6 маркийн $6\text{м}^3/\text{ц}$ хүчин чадалтай саарал ус гаргах цэвэрлэх төхөөрөмж суурилуулсан. Уг төхөөрөмжийн өмнөх дамжлагд өтгөн тунаах зориулалттай 4 ш 50 тн цуваа байрлалтай ёмкост суурилуулсан. WSZ-A-6 маркийн цэвэрлэх төхөөрөмж нь үндсэн 4 хэсгээс бүрдэнэ. Үүнд хүчилтөрөгчтэй орчинд амьдрах чадвартай бактери бүхий 2ш сав, неон гэрэл бүхий 1ш сав, дээж авах зориулалттай 1ш сав эдгээрээс бүрдэнэ. Мөн хүчилтөрөгч өгөх зориулалт бүхий 2ш компрессор байна. Сүүлийн дамжлагаас гарсан саарал ус нь ус хуримтлуулах усан санд орно. Хоногт 150 м^3 ус цэвэрлэх хүчин чадалтай.

5. Хаягдал усны хэмжээ /шоо метрээр/

2023 оны ус ашиглах дүгнэлтээр хаягдал усны хэмжээг унд ахуйд $2,736.0\text{ м}^3/\text{жил}$, бетон зуурмаг үйлдвэрлэхэд $6,000\text{ м}^3/\text{жил}$ ээр тооцов.

6. Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ, төрөл

“Хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын жишиг хэмжээг тогтоох тухай” 2019 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А-816/218 дугаартай Монгол Улсын байгаль, орчин аялал жуулчлалын сайд, Барилга, хот байгуулалтын сайдын хамтарсан тушаалын хавсралт

Ажилчдын тосгон- $1.5\text{ кг}/\text{м}^3$ Органик бодис (Химийн хэрэгцээт хүчил төрөгч)-ын жишиг хэмжээ, бетон зуурмаг үйлдвэрлэлд $0.8\text{ кг}/\text{м}^3$ -ээр тооцов.

7. Ус бохирдуулсны төлбөр тооцоо

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, Засгийн газрын 2019 оны 316 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ус бохирдуулсны төлбөрийн хэмжээ”, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Сангийн сайдын 2021 оны А-406/226 тоот хамтарсан тушаалаар баталсан “Хаягдал усны эзлэхүүн, бохирдуулах бодисын агууламжийг үндэслэн хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг тогтоох журам, тооцоолох аргачлал”-ыг тус тус үндэслэн тооцоход **445,200.00** /дөрвөн зуун дөчин таван мянга хоёр зуун/ төгрөг ногдож байна.

Унд ахуйд:

Органик бодис /XXX/: $2,736.0\text{ м}^3 \times (1.5\text{ кг}/\text{м}^3 \times 50\text{ төг}/\text{кг}) = 205,200.0$ (хоёр зуун таван мянга хоёр зуун) төгрөг ногдож байна.

Бетон зуурмаг үйлдвэрлэхэд:

№	Ашиглалтын зориулалт	Органик бодис /XXX/		Хаягдал усны хэмжээ, м ³	Бохирдуулах бодисын хэмжээ, кг	Бодис тус бүрийн төлбөрийн хэмжээ		Ус бохирдуулсны төлбөр, төгрөгөөр
		мг/л	кг/м ³			хэмжих нэгж	тариф	
1	2	3	4	5	$6=3*5*(10)^{-3}$	7	8	$9=6*8$
1	Бетон зуурмаг үйлдвэрлэлийн хаягдал ус	800	0.8	6,000.0	4,800.0	төг/кг	50	240,000.00
Нийт төлбөр, төгрөгөөр								240,000.00

8. Хууль тогтоомж, дүрэм, журам, норм стандартын талаар зөвлөмж

“Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2015” стандартын шаардлагыг хангасан хаягдал усыг байгальд нийлүүлэх, стандартаас давсан бол Усны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2, БОАЖ-ын Сайдын 2019 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн А/635 дугаар тушаалаар баталсан “Ус бохирдуулсны нөхөн төлбөрийг шатлан өсгөх хэлбэрээр ногдуулах журам”-ын дагуу нөхөн төлбөр ногдуулахыг анхаарах

9. Тавигдах шаардлага, цаашид авах арга хэмжээ

- “Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам” БОНХ-ийн Сайдын 2013 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн А-156 дугаар тушаалын 2.1.4, 3.6.1 дэх заалтыг мөрдөх;
- Усны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2-т заасны дагуу Дорноговь аймгийн Мандах сумын Засаг даргаас хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийн бичиг авах;
- Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт заасны дагуу Дорноговь аймгийн Мандах сумын Засаг даргатай “Ус бохирдуулсны төлбөрийн гэрээ” хийх;
- Улирал бүр хоёроос доошгүй хаягдал усны сорьц авч, хөндлөнгийн итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэн, сүүлийн сарын 15-ны дотор сав газрын захиргаанд ирүүлэх;
- Ус бохирдуулсны төлбөрийг дараа улирлын өмний сарын 20-ны дотор харьяалах татварын албанд төлөх

ХЯНАСАН:
ДАРГА

БОЛОВСРУУЛСАН:
УСНЫ БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, ҮЙЛДВЭР
ХЭДЭЭ АЖ АХУЙН УС, АШИГЛАЛТЫН
АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН




Б.ЯЛАЛТБАЯР

Э.ЖАНЧИВДОРЖ

Хүсэлтийн лавлах дугаар: GB155394202410241

Татсан огноо: 2024-10-24 14:43

Шилжүүлэгчийн дансны дугаар	Хүлээн авагчийн данс	Гүйлгээний дүн	Гүйлгээний төлөв
8140000215 MN750015008140000215	1165117377 MN030015001165117377	445,200.00 MNT	Амжилттай
Шилжүүлэгчийн нэр ЭРДЭНЭС ЦАГААНСУВАРГА ХХК	Хүлээн авагчийн нэр МТА.ТАТВАР	Гүйлгээний утга 3241002806369;64101408182;5824826;64101408182;9802	
	Хүлээн авагчийн банк Голомт банк	Гүйлгээний огноо 2024-10-24	



БАТЛАВ
МАНДАХ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Б.УГТАХБАЯР
2024 оны 05 сарын 13-ний өдөр

“ЭРДЭНЭС ЦАГААН СУВАРГА” ХХК-ТАЙ
БАЙГУУЛАХ ХОГ ХАЯГДЛЫН ГЭРЭЭ

2024 оны 05 сарын 13 өдөр

№01 079-5124 Төхөм баг

Нэг: Нийтлэг үндэслэл

1.1 Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 4, 10 дугаар зүйлийн 2 дахь заалт, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 02/09 дугаар тогтоол зэрэг нь энэхүү гэрээний эрх зүйн үндэслэл болно.

Энэхүү гэрээг нэг талаас Мандах сумын Засаг даргын Тамгын газрын дарга Ц.Сосор, нөгөө талаас “ЭРДЭНЭС ЦАГААН СУВАРГА” ХХК-ний гүйцэтгэх захирал Г.Цогт нар харилцан тохиролцож байгуулав.

Хоёр: Гэрээний зорилго

2.1 Хог хаягдлын хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг санхүүжүүлж, төсвийн орлогыг бүрдүүлэхэд оршино.

Гурав: Сумын Засаг даргын Тамгын газрын хүлээх эрх, үүрэг

3.1 Хог хаягдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих

3.2 Аж ахуйн нэгж байгууллагын хог хаягдал хаях түр цэгийг тогтоож, мөрдүүлэх

3.3 Хог хаягдал гаргасны төлбөрийг тухайн сарын 30-ны дотор төвлөрүүлэх, түүний хэрэгжилтэнд хяналт тавих

Дөрөв: “ЭРДЭНЭС ЦАГААН СУВАРГА ” ХХК-ийн хүлээх эрх, үүрэг

- 4.1 Зориулалтын цэгээс бусад газарт хог хаягдал хаяхгүй байх
- 4.2 Орчны газрынхаа хог хаягдлыг цэвэрлэх
- 4.3 Хог хаягдлын талаарх дүрэм, журам, стандартын шаардлагыг хангаж ажиллах
- 4.4 Үүсгэсэн хог хаягдал болон аюултай хог хаягдлын мэдээллийг нутгийн захиргааны байгууллагад үнэн зөв мэдээллэж аюулгүй байдлыг хангах
- 4.5 Хог хаягдлыг ялган ангилж хэвших
- 4.6 Гэрээнд заасны дагуу сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/12 дугаар тогтоолоор баталсан хог хаягдал гаргасны сарын төлбөрийг 150,000 /нэг зуун тавин мянган төгрөг/-өөр тооцож төлбөрийн даалгаварын дагуу төлж барагдуулна.

Ажилчдын кемп 150000 төгрөг 12 сараар = 1,800,000 (Нэг сая найман зуун мянган төгрөг)

Тав: Бусад нөхцөл

5.1 Хог хаягдал гаргасны төлбөр өөрчлөгдсөн тохиолдолд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулна.

5.2 Гэрээгээр 2024 оны төлбөр тооцогдоно. 2024 оны 12 сарын 31-ны өдрөөр гэрээний хугацаа дуусгавар болно.

Гэрээ байгуулсан:

МАНДАХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМБЫН ГАЗРЫН ДАРГА



"ЭРДЭНЭС ЦАГААН СУВАРГА" ХХК-НЫ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ





БАТЛАВ.

“МОНГОЛЫН АЛТ” (МАК) ХХК-ИЙН
ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЦЭЛМҮҮН - 2

ХОГ ХАЯГДАЛ НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

2023 он 07 сар 20 өдөр

№

655-1123

Улаанбаатар хот

Нэг талаас: Монгол Улсын хуулийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа эрхэлж буй “Төвшин сайхан мөнх” НҮТББ (цаашид “А тал” гэх), түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал О.Лхагвасүрэн,

Нөгөө талаас: Монгол Улсын хуулийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа эрхэлж буй “Монголын алт” (МАК) ХХК (цаашид “Б тал” гэх), түүнийг төлөөлж Хангамж техник үйлчилгээний газрын захирал Д.Нинжбадгар, бид нар (цаашид хамтад нь “Талууд” гэх) Монгол Улсын Иргэний хуулийг удирдлага болгон дор дурдсан нөхцөлийг харилцан тохиролцож энэхүү хамтран ажиллах гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г байгуулав.

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. Энэхүү гэрээний зорилго нь Б тал болон түүний охин, хараат мөн хамаарал бүхий компаниудаас гарах дахин боловсруулах боломжтой хаягдал (цаашид “дахивар нөөц” гэх)-г тогтмол хуримтлуулан А талд хүлээлгэн өгөхтэй холбоотой харилцаанд Талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхой болгон зохицуулахад оршино.
- 1.2. Талуудын эрх бүхий албан тушаалтан гэрээнд гарын үсэг зурж, тамга даран баталгаажуулсан өдрөөс эхлэн гэрээ хүчин төгөлдөр болно.
- 1.3. Энэхүү гэрээ нь дараах хавсралтуудтай байх бөгөөд эдгээр нь гэрээний салшгүй хэсэг байна.
Үүнд:
Хавсралт № 1-Үнийн задаргаа.

ХОЁР.ГЭРЭЭНИЙ ЗҮЙЛ, ХУГАЦАА

- 2.1. Энэхүү Гэрээний хүрээнд Б тал болон түүний охин, хараат мөн хамаарал бүхий компаниуд нь өөрсдийн үйл ажиллагаанаас гарах дахин боловсруулах боломжтой хаягдал (цаашид “дахивар нөөц” гэх)-ийг хуримтлуулан А талд хүлээлгэн өгнө.
- 2.2. А тал Б талын охин, хараат мөн хамаарал бүхий компаниудаас гарах дахивар нөөцийг захиалгын дагуу тохиролцсон хугацаанд очиж авна.
- 2.3. Нийлүүлэгч болон түүний охин, хараат, компани мөн түүний хамаарал бүхий компани гэдэгт дараах компаниудыг ойлгоно. Үүнд:

№	Компани	Регистрийн дугаар
1	“Монголын Алт” (МАК) ХХК	2095025
2	“Хүрэн толгой коал майнинг” ХХК	2697947
3	“МАК Цемент” ХХК	5830974
4	“Эрдэнэс цагаан суварга” ХХК	5824826
5	“МАК Аранжин зэс”	5849187
6	“Тру ти ар си” ХХК	6610188

- 2.4. Нэг удаагийн ачилт нь 3-4 тонн хэмжээтэй байна.
- 2.4. Энэхүү гэрээг 2023 оны 07-р сарын 20-ний өдрөөс 2024 оны 07-р сарын 20-ний өдөр хүртэлх хугацаанд байгуулсан болно.
- 2.5. Гэрээг талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр хугацаанаас нь өмнө дуусгавар болгож болно.

ГУРАВ. ҮНЭ, ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

- 3.1. Б тал нь А талд тээврийн зардалд гэрээний 2.3-т заасан хэмжээгээр 50 км тутамд 150,000 /нэг зуун тавин мянган/ төгрөгийг төлнө. /Үйлдвэр уурхайгаас очиж ачиж тээвэрлэсэн тохиолдол/
- 3.2. А тал нь Б талын Улаанбаатар хот дахь борлуулалтын цэгүүд, засвар үйлчилгээний төвөөс дахивар нөөц авах тохиолдолд 3.1-т заасан тээврийн төлбөр тооцогдохгүй болно.
- 3.3. Б тал нь дахивар нөөцийг энэхүү гэрээний Хавсралт №1-т заасан үнээр тооцож А талд нийлүүлнэ.
- 3.4. Ачилт хийхээс өмнө Талууд хамтран дахивар нөөцийг жинлэн, хэмжээг акт үйлдэн баталгаажуулна.
- 3.5. Энэхүү гэрээний 3.4-д заасан акт нь гэрээний төлбөр төлөх баримт болно.
- 3.6. А тал нь гэрээний үнийг гэрээний Хавсралт №1-д заасан тарифын дагуу тооцон ачилт хийснээс хойш ажлын 5 хоногт багтаан Б талын нэхэмжлэхийг үндэслэн төлнө.
- 3.7. А талын төлөх төлбөрөөс энэхүү гэрээний 3.1-т заасан тээврийн зардлыг Б талын санаачилгаар тухай бүр хасаж тооцож болно.
- 3.8. Б талын дансны мэдээлэл: **Голомт банкны 8140000114** тоот төгрөгийн данс.

ДӨРӨВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

4.1 А талын эрх, үүрэг:

- 4.1.1. А тал нь Б талаас дахивар нөөцийг аливаа механик бохирдолгүй, ангилж, нийлүүлэхийг шаардах эрхтэй.
- 4.1.2. А тал нь Б талаас шаардлага хангаагүй дахивар нөөцийг хүлээн авахгүй байх эрхтэй.
- 4.1.3. А тал нь Б талаас гарах дахивар нөөцүүдийн төрөл, хэрхэн хураах, хадгалах тал дээр зааварчилгаа өгөх үүрэгтэй.
- 4.1.4. А тал нь Б талаас гарах дахивар нөөцийг төлөвлөсөн хугацаандаа тогтмол хүлээн авах үүрэгтэй.
- 4.1.5. А тал нь дахивар нөөцийг ачихдаа Б талын өдөр тутмын үйл ажиллагаанд саад болохгүйгээр гүйцэтгэх үүрэгтэй.
- 4.1.6. А тал нь Б талын үйлдвэр уурхайн бүсэд өөрийн ажилчдын ХАБЭА-н шаардлагыг ханган ажиллуулах үүрэгтэй.
- 4.1.7. А тал нь гэрээний 4.1.6.-д заасан үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс аливаа эрсдэл, хохирол учирсан тохиолдолд Б тал хариуцлага хүлээхгүй.
- 4.1.8. А тал нь Б талын бэлтгэсэн дахивар нөөцийг үнэн зөвөөр тооцоолон хүлээн авах үүрэгтэй.
- 4.1.9. А тал нь дахивар нөөцийг тогтсон хугацаандаа хүлээн авах боломжгүй тохиолдолд урьдчилан мэдэгдэх үүрэгтэй.
- 4.1.10. А тал нь Б талыг хог хаягдлаа авчирч хүлээлгэн өгөх боломжгүй үед Б талын хүсэлтийн дагуу очиж авах үүрэгтэй.

4.2 Б талын эрх, үүрэг:

- 4.2.1. Б тал нь А талаас гэрээгээр тохирсон төлбөрийг энэхүү гэрээнд заасан нөхцөлийн дагуу төлөхийг шаардах эрхтэй.
 - 4.2.2. Б тал нь дахивар нөөцийг А талаас өгсөн зааврын дагуу ямар нэг үлдэгдэлгүй, бохирдолгүй, ангилан бэлтгэн нийлүүлэх үүрэгтэй.
 - 4.2.3. Б тал нь А талд дахивар нөөцийг хүлээн авах, ачилт хийхтэй холбоотой үйл ажиллагааны зааварчилгааг өгөх үүрэгтэй.
 - 4.2.4. Б тал нь А талд өөрийн байгууллагаас гарах бүхий л дахивар нөөцийг өгөх үүрэгтэй.
- 4.3 Талууд гэрээний хэрэгжилт, гэрээний талаарх үйл ажиллагаанд хяналт тавих эрхтэй.
 - 4.4 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Талууд харилцан шаардах эрхтэй.

ТАВ. ХАРИУЦЛАГА

- 5.1 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ зохих журмын дагуу гүйцэтгээгүйгээс нөгөө талдаа хохирол учруулсан бол учирсан бодит хохирлыг нөхөн төлүүлэхээр шаардах эрхтэй. Бодит хохирол гэдэгт хохирогч талд учирсан шууд хохирол болон түүний гуравдагч этгээдийн өмнө хүлээсэн хариуцлагыг ойлгоно.
- 5.2 Гэрээнд зааснаас бусад асуудлаар Талууд өөр хоорондын ашиг сонирхлыг хөндсөн хөндлөнгийн аливаа үйлдэл хийхгүй байх.
- 5.3 А тал нь ажил үүргийн дагуу, Б тал болон түүний хараат мөн хамаарал бүхий компаниудын талаар олж мэдсэн аливаа мэдээ, мэдээллийг бусдад дамжуулахгүй, хэвлэн нийтлэхгүй байх үүрэгтэй. Энэ үүргээ зөрчсөнөөс үүссэн хохирлын А тал бүрэн хариуцна.

ЗУРГАА. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

- 6.1 Давагдашгүй хүчин зүйл /гал түймэр, газар хөдлөлт, террорист үйлдэл, ажил хаялт г.м/-ийн нөхцөл байдлын шууд болон шууд бус үйлдлийн улмаас талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй тохиолдолд гэрээний үйлчлэх хугацааг тухайн нөхцөл байдлыг арилгах хүртэл хойшлуулж болно.
- 6.2 Гэрээний үүргийг биелүүлэхэд саад болох нөхцөл байдал үүссэн, дууссан тухай талууд нэн даруй нэг нэгэндээ цахимаар буюу бичгээр мэдэгдэнэ.

ДОЛОО. БУСАД ЗҮЙЛ

- 7.1 Хамтын ажиллагааны удирдлагыг талууд гэрээг байгуулагдсан үеэс хамтран хэрэгжүүлэх ба ийнхүү хамтран хэрэгжүүлэхдээ тэгш эрхтэйгээр оролцоно.
- 7.2 Талууд харилцан тохиролцож гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба энэ нэмэлт, өөрчлөлтийг энэхүү гэрээнд бичгээр болон хавсралтаар оруулсан нөхцөлд уг өөрчлөлт хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 7.3 Энэ гэрээнээс үүсэх аливаа маргааныг талууд аль болох эвлэрэх замаар шийдвэрлэхийг эрмэлзэх ба боломжгүй бол Монгол Улсын шүүхэд хандаж шийдвэрлүүлнэ.
- 7.4 Гэрээнд оролцогч аль нэг талын удирдлага, үйл ажиллагааны чиглэлд ямарваа нэг өөрчлөлт орсон ч гэрээнд тусгагдсан заалтууд хүчин төгөлдөр хэвээр хадгалагдана.
- 7.5 Энэхүү гэрээг 3 хувь үйлдэх бөгөөд А тал 1 хувийг, Б тал 2 хувийг хадгалах ба хуулийн адил хүчинтэй байна.

ТАЛУУДЫН АЛБАН ЁСНЫ ХАЯГ

А тал:

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
2-р хороо, сэлбэ 10-р гудамж, 91 тоот

Утас: 9668-5858, 8813-0083

Б тал:


Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг,
1-р хороо, 19-р хороолол, Чингисийн өргөн
Чөлөө, төв байр-44

Утас: 7575-9700

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН


А талыг төлөөлж:

Гүйцэтгэх захирал О.Лхагвасүрэн

.....


Б талыг төлөөлж:

ХТҮГ-ын Захирал Д.Нинжбадгар

.....


ЭЗГ-ын Ахлах хуульч, газрын захирлын
үүргийг хавсран гүйцэтгэгч Т.Жавхлан

.....


655-1123


..... тоот гэрээний хавсралт №1

Үнийн задаргаа

ДАХИВАР НӨӨЦ		ҮНЭ - 1кг/₮		
		Төв	Очиж авах	
ЗЭС	Гялгар	17500	8750	
	Бохир	16500	8250	
ГУУЛЬ	Гууль	6500	3250	
ХАЙЛШ	Хайлш	3800	1900	
	Хөнгөн цагаан	3800	1900	
Радиатор		6500	3250	
ТУГАЛГА	Шинэ	1500	750	
	Бохир	1000	500	
АККУМЛЯТОР		500	250	
Батерей		500	250	
ТӨМӨР	Зузаан төмөр	200	100	
	Нимгэн төмөр	200	100	
	Ган	200	100	
	Ширэм	200	100	
БУСАД	Тоног төхөөрөмж	+	+	
	Мотор, хроп	+	+	
	Хаягдал машин - 90.000₮-1сая.₮			
	Кузов - 10.000₮-30.000₮			
ГЯЛГАР УУТ	Пакет /бүт.савлагаа/	1000	500	
	Зөөлөн	500	250	
ХУВАНЦАР	Ус, ундааны /PET/	350	175	
	Ахуйн зөөлөн /HDPE/	400	200	
	Авдар, подон /PP/	100	50	
	Вакум цонхны /PVC/	300	150	
	Хөөсөнцөр	-	-	
Лааз		2000	650	
ЦААС	Цагаан цаас	50	20	
	Бор цаас	60	20	


А талыг төлөөлж:

Гүйцэтгэх захирал О.Лхагвасүрэн

.....


Б талыг төлөөлж:

ХТҮГ-ын Захирал Д.Нинжбадгар

.....


БАТЛАВ:

“МОНГОЛЫН АЛТ” (МАК) ХХК
-ИЙН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЦЭЛМҮҮН



БАТЛАВ:

“ТҮМЭН ЭГШИГ” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛТ ЧИНЗОРИГ



АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ШИЛЖҮҮЛЭХ ГЭРЭЭ

2021 оны 10 сарын 13-ний өдөр

№

964-1121

Улаанбаатар хот

Нэг талаас “Түмэн-Эгшиг” ХХК /цаашид “Хүлээн авагч” гэх/, түүнийг төлөөлж Ерөнхий менежер Б.Одбаяр,

Нөгөө талаас “Монголын Алт” (МАК) ХХК /цаашид “Үүсгэгч” гэх/, түүнийг төлөөлж Хангамж, техник үйлчилгээний газрын Захирал Д.Нинжбадгар бид нар харилцан тохиролцож Монгол Улсын Иргэний хууль, Хог хаягдлын тухай хууль, Засгийн газрын 2018 оны 116-р тогтоолын 1, 2-р хавсралт болох “Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх тайлагнах журам”, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 02-р сарын 02-ны өдрийн А/21 тоот тушаал болон Байгаль орчны аюулгүй байдалтай холбогдох хууль, журмыг үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

НЭГ. ГЭРЭЭНИЙ АГУУЛГА

- 1.1. Энэхүү гэрээгээр Аюултай хог хаягдал үүсгэгчээс аюултай хог хаягдлын дагалдах бичгийн дагуу түүнээс гарч байгаа аюултай хог хаягдлыг хүлээн авагч нь хүлээн авч түр хадгалах, дахин боловсруулах, устгалд оруулах, үүсгэгч нь хүлээн авагчид тохиролцсон үнийг төлөх болон талуудын эдлэх эрх, үүрэг хариуцлагын талаар зохицуулна.
- 1.2. Энэ гэрээгээр шууд зохицуулагдаагүй бусад харилцааг Монгол Улсын Хог хаягдлын тухай хууль, Иргэний хууль болон бусад хууль тогтоомжоор зохицуулна.
- 1.3. Үүсгэгч гэдэгт “Монголын Алт” (МАК) ХХК болон дор дурдсан түүний охин болон хамаарал бүхий компанийг хамтад нь ойлгоно. Үүнд:
 - 1.3.1. “МАК Цемент” ХХК;
 - 1.3.2. “Хүрэн толгой коал майнинг” ХХК;
 - 1.3.3. “Эрдэнэс цагаан суварга” ХХК;
 - 1.3.4. “Тру ти ар си” ХХК.
- 1.4. Аюултай хог хаягдлын тоо хэмжээ, төрөл болон үнийн талаар гэрээний Хавсралт 1-т тусгах ба талууд гэрээний хугацаанд аюултай хог хаягдлыг шилжүүлэх бүртгээ дагалдах бичгийг гэрээнд хавсаргах ба энэ нь гэрээний салшгүй хэсэг байна.

ХОЁР. АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 2.1. Аюултай хог хаягдлыг ангилан ялгаж “Аюултай хог хаягдал” гэсэн тэмдэглэгээ хийсэн байна.
- 2.2. Аюултай хог хаягдал савласан сав бүр нь ямар химийн бодис хадгалж байсан тухай нэр шошготой байна.
- 2.3. Үүсгэгч нь аюултай хог хаягдлыг шилжүүлэх бүртгээ үүссэн болон хуримтлагдсан хог хаягдлын хэмжээний талаарх бүртгэлийг хүлээн авагчид шилжүүлнэ.
- 2.4. Аюултай хог хаягдлыг шилжүүлэхдээ БОАЖЯ Сайдын 2018 оны 02-р сарын 02-ны өдрийн А/21 тоот тушаалын 1-р хавсралтад заасан маягтын дагуу дагалдах бичгийг бүрдүүлж өгнө.
- 2.5. Аюултай хог хаягдлын савыг суллаж онц хортой, тэсрэмтгий, шатамхай бодис /тухайлбал цианид натри гэх мэт/ -г тухайн бодисын шинж чанарт тохирсон уусмалаар цэвэрлэсэн байна. Хоосон сав нь ЗГ-н 2018 оны 116-р тогтоолын 1-р хавсралтын 5.7-5.9-д заасан шаардлагыг хангасан байвал зохино.

ГУРАВ. АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫГ ШИЛЖҮҮЛЭХ ХУГАЦАА, ТӨЛБӨР ТӨЛӨХ НӨХЦӨЛ

- 3.1. Гэрээний үргэлжлэх хугацаа нь 2021 оны 10 сарын 13-ны өдрөөс 2022 оны 10 сарын 13-ны өдрийг хүртэл 1 (нэг) жилийн хугацаатай байна.
- 3.2. Энэхүү гэрээний 1-р хавсралтад заасан Үүсгэгчээс гарах хаягдлын урьдчилсан төлөвлөгөөний дагуу аюултай хог хаягдлын хуримтлал үүссэн тохиолдолд үүссэн хаягдлын хэмжээнээс хамаарч 90-ээс 180 хоногт аюултай хог хаягдлыг хүлээн авагчид шилжүүлсэн байна.
- 3.3. Үүсгэгч нь аюултай хог хаягдлаа шилжүүлэх тухай хүсэлтээ хүлээн авагчид албан бичгээр эсвэл chemicalwasterisk@gmail.com и-мэйл хаягаар 5-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдэнэ. Хүлээн авагч үүсгэгч болон тээвэрлэгчтэй харилцан тохиролцож хүлээн авагчийн байранд аюултай хог хаягдал хүргэх хугацааг товлон.
- 3.4. Хүлээн авагч нь үүсгэгчээс аюултай хог хаягдал шилжин ирэх товлосон өдөр, цагт аюултай хог хаягдлыг хүлээн авах хариуцсан ажилтнаа бэлэн байлгаж, зохих журмын дагуу хаягдлыг хүлээн авна.
- 3.5. Үүсгэгч нь аюултай хог хаягдлыг шилжүүлэхдээ аюултай хог хаягдлын хэмжээ, тоо ширхгийг гэрээний Хавсралт №1-т заасан төлбөр тооцооны тарифт үнээр тооцож аюултай хог хаягдлыг шилжүүлнэ.
- 3.6. Аюултай хог хаягдлыг хүлээн авагч хүлээн авах үед Үүсгэгчээс ирүүлсэн дагалдах бичигт дурдсан мэдээлэл зөрснөөс үүдэж гэрээний үнэ өөрчлөгдөж болно. Энэ тохиолдолд хог хаягдлыг хүлээн авах үед тооцож гаргасан үнээр бодож үүсгэгч хүлээн авагчид төлбөрийг төлнө.
- 3.7. Хүлээн авагч нь Үүсгэгчийн ирүүлсэн аюултай хог хаягдлыг Хавсралт №1-т заасан тарифт үнээс 5 хувийн хөнгөлөлттэй үнээр устгана.
- 3.8. Үүсгэгч нь гэрээний 3.5, 3.6-д заасан төлбөрийг “Түмэн-Эгшиг” ХХК-ийн Худалдаа хөгжлийн банкны **499085408** тоот дансанд нэхэмжлэхийн дагуу төлнө. Үүнд:
 - 3.8.1. Аюултай хог хаягдлыг хүлээн авагчид шилжүүлэх тухай захиалга өгснөөс хойш ажлын 3 хоногийн дотор төлбөрийн 40 хувийг,
 - 3.8.2. Аюултай хог хаягдлыг хүлээн авагчид шилжүүлэн өгч дагалдах бичгийн 1 хувь буцан ирснээс хойш ажлыг 5 хоногийн дотор төлбөрийн үлдэгдлийг.
- 3.9. Үүсгэгч нь хүлээн авагчийн тусгай зориулалтын тээврийн хэрэгслээр аюултай хог хаягдлыг тээвэрлүүлж, хүргэлтийн цэг дээр хүргүүлж болно. Хүлээн авагчийн тээврийн хэрэгслээр хог хаягдал ачиж, тээвэрлүүлэх тохиолдолд Хавсралт №2-т заасан үнийн дагуу Тээвэрлэлтийн зохих төлбөрийг төлнө.

ДӨРӨВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

- 4.1 Үүсгэгчийн эрх, үүрэг:
 - 4.1.1 Үүсгэсэн аюултай хог хаягдлаа гэрээнд заасан хугацааны дотор хүлээн авахыг хүлээн авагчаас шаардах эрхтэй.
 - 4.1.2 Үүсгэгч нь гэрээний 2.5-д заасан шаардлагыг хангасан аюултай хог хаягдлыг Хүлээн авагчид хүлээлгэн өгнө.
 - 4.1.3 Үүсгэгч нь Аюултай хог хаягдлын дагалдах бичгийг 4 хувь үйлдэж, гарын үсэг тамга тэмдэг дарж өөртөө 1 хувь, тээвэрлэгчид 1 хувь, хүлээн авагчид 2 хувийг илгээж, хүлээн авагчаас хүлээн авсан гарын үсэг, тамга тэмдэг дарагдсан 1 хувь дагалдах бичгийг буцаан авна.
 - 4.1.4 Аюултай хог хаягдлыг хүлээн авагчид хүргэх тээврийн зардлыг хариуцна.
 - 4.1.5 Үүсгэгч Аюултай хог хаягдлыг хүлээн авагчаар тээвэрлүүлэхээр бол тусад нь аюултай хог хаягдал тээвэрлэх гэрээ байгуулна.
 - 4.1.6 Гэрээгээр тохиролцсон төлбөрийг Хүлээн авагчид хугацаанд нь төлнө.
 - 4.1.7 Шилжүүлэх аюултай хог хаягдлын талаарх мэдээллийг хүлээн авагчид үнэн зөв мэдээлнэ. Худал, буруу ташаа мэдээлснээс бусдын эрүүл мэнд, амь нас, талуудын эд хөрөнгө болон байгаль орчинд хохирол учирвал үүнээс үүсэх хохирлыг үүсгэгч хариуцна.
 - 4.1.8 Үүсгэсэн аюултай хог хаягдлаа Хүлээн авагчид шилжүүлэх тухайгаа 5-аас доошгүй хоногийн өмнө хүлээн авагчид мэдэгдэнэ.
- 4.2 Хүлээн авагчийн эрх, үүрэг

- 4.2.1 Үүсгэгчээс шилжүүлсэн аюултай хог хаягдал нь гэрээний 2.5-д заасан шаардлагыг хангаагүй, дагалдах бичигт үл зохицол үүссэн, тоо, хэмжээтэйгээ зөрж байвал Үүсгэгчийн төлөөлөгчид мэдэгдэж зохих арга хэмжээг авах үүрэгтэй.
- 4.2.2 Аюултай хог хаягдал хүлээн авсан төлбөр тооцоог Үүсгэгчээс гэрээнд заасан хугацааны дотор төлөхийг шаардах эрхтэй.
- 4.2.3 Аюултай хог хаягдлыг хүлээж авсан актыг үүсгэгчид гаргаж өгнө.
- 4.2.4 Хүлээн авагч аюултай хог хаягдлыг хүлээн авснаас хойших түүний хадгалалт, устгал, дахин боловсруулалтыг хариуцна.
- 4.2.5 Үүсгэгчээс Аюултай хог хаягдал шилжиж ирэх үед хариуцсан ажилтнаа бэлэн байлгаж, зохих журмын дагуу хаягдлыг хүлээн авна.

ТАВ. АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫГ ШИЛЖҮҮЛЭХ, ШИЛЖҮҮЛЭН АВАХ

- 5.1. Үүсгэгч гэрээгээр тохиролцсон хугацаандаа аюултай хог хаягдлыг хүлээн авах цэг буюу Төв аймаг, Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт орших Хүлээн авагчийн аюултай хог хаягдал устгах үйлдвэрт хүргэнэ.
- 5.2. Үүсгэгч гэрээнд заасан шилжүүлэх хугацаанаасаа өмнө аюултай хог хаягдлыг шилжүүлэх эрхтэй ба ингэх тохиолдолд Хүлээн авагчид энэ тухай 5-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдсэн байна.
- 5.3. Үүсгэгч аюултай хог хаягдлаа “Аюултай хог хаягдал” тээвэрлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжийн тусгай зориулалтын, зохих тэмдэг тэмдэглэгээтэй тээврийн хэрэгслээр ачиж, тээвэрлүүлэн Хүлээн авагчид хүргэж өгнө.
- 5.4. Талууд аюултай хог хаягдлыг хүлээлцэхдээ дагалдах бичиг болон гэрээнд заасан тоо, хэмжээтэй нийцэж байгаа эсэх, үл зохицол байгаа эсэхийг шалгах ба нийцэж байвал энэ тухай акт үйлдэж гарын үсэг зурж хүлээн авагч хүлээн авна.
- 5.5. Хүлээн авагч нь үүсгэгчийн шилжүүлэн өгсөн аюултай хог хаягдлыг Хог хаягдлын тухай хууль, болох “Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх тайлагнах журам”-ын шаардлагад нийцүүлэн хадгалах, дахин боловсруулах, устгалд оруулах ажиллагааг хариуцан гүйцэтгэх бөгөөд түүнийг зөрчсөний улмаас үүссэн хариуцлагаас Үүсгэгчийг ангид байлгана.
- 5.6. Үүсгэгч нь аюултай хог хаягдлыг Хүлээн авагчид дагалдах бичгээр хүлээлгэн өгснөөс хойших аливаа асуудалд хариуцлаа хүлээхгүй болно.

ЗУРГАА. ӨМЧЛӨХ ЭРХ ШИЛЖИХ

- 6.1. Үүсгэгч нь аюултай хог хаягдлыг Хүлээн авагчид дагалдах бичгээр хүлээлгэн өгөх хүртэл хог хаягдлын өмчлөгч байна.
- 6.2. Үүсгэгч нь хог хаягдлыг Хүлээн авагчид ачиж, тээвэрлэн хүлээн авах цэг дээр дагалдах бичгээр хүлээлгэн өгснөөр өмчлөх эрх хүлээн авагчид шилжсэн гэж үзнэ.
- 6.3. Аюултай хог хаягдлыг хүлээн авах цэг дээр Хүлээн авагчид хүлээлгэн өгөх хүртэл түүний үр шим, эрсдэл үүсгэгчид байх ба хүлээн авагчид хүлээлгэн өгснөөр үр шим, эрсдэл хүлээн авагчид шилжинэ.

ДОЛОО. ХАРИУЦЛАГА, МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 7.1. Аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн эсхүл үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас нөгөө талдаа учирсан аливаа хохирлыг холбогдох нотлох баримтад үндэслэн бүрэн хариуцаж нөхөн төлнө.
- 7.2. Үүсгэгч энэ гэрээний 3.7.2-д заасны дагуу үнийг төлөх хугацааг хэтрүүлсэн бол Талууд харилцан тохиролцож уг хугацааг сунгаснаас бусад тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг хэтрүүлсэн хоног тутамд Хүлээн авагчид төлнө.
- 7.3. Хэрэв Хүлээн авагч нь Үүсгэгчээс ирүүлсэн хог хаягдлыг энэ гэрээний 3.2-т заасан хугацааны дотор зохих журмын дагуу хүлээн аваагүй, хугацааг хожимдуулсан бол Талууд харилцан тохиролцож уг хугацааг сунгаснаас бусад тохиолдолд гэрээгээр тохиролцсон үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг хэтрүүлсэн хоног тутамд Үүсгэгчид төлнө.
- 7.4. Талууд гэрээнээс татгалзах болон цуцлах үндэслэлийг Иргэний хуулиар зохицуулна.

- 7.5. Үүсгэгч аюултай хог хаягдлыг хүлээн авагчид шилжүүлэхдээ дагалдах бичиг болон гэрээний хавсралт 1-д заасан тоо хэмжээ, химийн бодисын нэр хаягийг үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй бөгөөд буруу, зөрүүтэй худал мэдээлснээс болж гэрээний үнийн дүн өөрчлөгдөх, эсвэл үүнээс үүдэж хохирол учирвал хүлээн авагч хариуцахгүй болно.
- 7.6. Энэ гэрээтэй холбогдон Талуудын хооронд үүссэн аливаа санал зөрөлдөөн, маргаантай асуудлыг Талууд эв зүйгээр хэлэлцэн шийдвэрлэхийг чармайх бөгөөд ийнхүү шийдвэрлэж чадаагүй бол маргааныг Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

НАЙМ. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ


- 8.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал гэдэгт үерт автах, гал түймэрт нэрвэгдэх, дэлбэрэлтэд өртөх, газар хөдлөх, зуд болох, тахал болон бусад байгалийн хүчин зүйлс мөн цэрэг дайны үйл ажиллагаа, төрийн эрх барих байгууллагын шийдвэр буюу экспорт, импортын хориг зэрэг талуудын үйл ажиллагаанаас үл хамаарах үндэслэлээр энэхүү гэрээг зохих ёсоор биелүүлэх боломжгүй байдлыг бий болгохыг ойлгоно.
- 8.2. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас гэрээ биелэгдэх боломжгүй тохиолдолд талууд бие биедээ нэн даруй мэдэгдэх ба гэрээний хугацаа дээрх нөхцөл байдал арилах хүртэл хугацаагаар сунгагдах буюу тодорхой хугацаа зааж сунгаж болно.
- 8.3. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас бараа материал утсан, дутсан тохиолдолд шилжүүлэн хүлээлгэн өгөх хүртэлх эрсдэлийг үүсгэгч, шилжүүлэн хүлээн авснаас хойших эрсдэлийг хүлээн авагч хариуцна.
- 8.4. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлыг зохиомлоор буюу болгоомжгүйгээр бий болгосноос бусад тохиолдолд форс мажорын нөхцөлөөс шалтгаалан учирсан хохирлыг хариуцах үүргээс талууд чөлөөлөгдөнө.

ЕС. БУСАД ЗҮЙЛ

- 9.1. Энэхүү гэрээний хэрэгжилтийн явцад гэрээнд аливаа нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд бичгээр үйлдэж эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, тамга даран баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 9.2. Талуудын аль нэг нь гэрээний 3.1-т заасан хугацаа дуусгавар болсны дараа Гэрээг цуцлах санал гаргаагүй тохиолдолд Гэрээг дахин 1 жилийн хугацаагаар сунгагдсанд тооцно.
- 9.3. Гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг зөвхөн бичгээр оруулах ба талуудын эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зурж, тамга даран баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 9.4. Энэхүү гэрээг Монгол хэл дээр долоон хувь үйлдэж, Үүсгэгч 6 хувь, Хүлээн авагч 1 хувийг тус тус хадгалсан нь хуулийн ижил хүчинтэй.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Үүсгэгчийг төлөөлж:
ХТҮГ-ын Захирал Д.Нинжбадгар

.....


Хуульч Б.Жанчив

.....


Хүлээн авагчийг төлөөлж:
Ерөнхий менежер Б.Одбаяр

.....




ОЛЫ
АЮУ
ҮЙН

**ХИМИЙН ХОРТОЙ БОДИС ХАДГАЛСАН ХАЯГДАЛ ХУВАНЦАР САВ
ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛСНИЙ ТАРИФ**

(тээврийн зардал багтаагүй үнэ болно)

№	Үйлчилгээний төрөл	Хэмжих нэгж	Тоо, хэмжээ	Нэгж үнэ /төг/ НӨАТ тооцоогүй дүн
1	Химийн бодисын хаягдал хуванцар, сав, канистр /0,5л, 1л, 2,5л, 5л, 10л,	тн	1	1150000
2	Химийн хуванцар торх / 100л/	ш	1	4800
3	Химийн хуванцар торх /200л/	ш	1	5600
4	Химийн хуванцар ИВС танк /1000л/	ш	1	20000
5	Гялгар уут, шуудай, /25кг, 50кг, 1тн big bag шуудай/	тн	1	1250000
6	Төмөр торх поошиг	ш	1	4200
7	Химийн бодисын шил, сав	кг	1	1500
8	Капель, Тигл шаазан сав	кг	1	1600
9	Химийн хаягдал шингэн уусмал 1литр	л	1	3500-4500
10	Хаягдал аккумулятор	ш	1	5000
11	Масло шүүр том оврын	ш	1	3800
12	Принтер хор	ш	1	2500
13	Хаягдал агаар шүүгч филтэр	ш	1	4000
14	Хаягдал лаг	тн	1	950000
15	Хаягдал цаас	кг		400
16	Хаягдал маск болон бээлий нийлэг материал	кг	1	1500
17	Хаягдал шингээгч даавуу химийн бодистой	кг	1	3500
18	Хаягдал төмөр материал болон бусад	кг	1	2500
19	Хаягдал лааз сав	ш	1	1100
20	Хаягдал батарей	кг	1	3500
21	Ашигласан масло тос	1 литр	1	800
22	Хөргөлтийн шингэн тосол	1 литр	1	1000
23	Галын хорны баллон том жижиг/дунд	1ш	1	3500-4800


НА
ХК
17

24	Бохирдсон хөрс тостой	тонн	1	1600000
25	Эмнэлгийн хаягдал	кг	1	5500
26	Хаягдал аккумулятор	кг	1	3500
27	Хаягдал Battery	кг	1	1800
28	Хаягдал дугуй /том/	ш	1	12000-25000
29	Хүчил ба шингэн хаягдал	л	1	4200
30	Азотын хүчил	г	1	4200
31	Аммиак	г	1	4200
32	Давсны хүчил	кг	1	3800
33	Хүхрийн хүчил	кг	1	3800
34	Цууны хүчил	кг	1	3800
35	Фосфорын хүчил	кг	1	3800
36	Хлорт натри	кг	1	4200
37	Техникийн сальфитка, Алчуур шингээгч даавуу	кг	1	3500
38	Натри	л	1	3500
39	Хуурай бодис	кг	1	4200

ХАВСРАЛТ БАТАЛСАН:

Үүсгэгчийг төлөөлж:

ХТҮГ-ын Захирал Д.Нинжбадгар



Хүлээн авагчийг төлөөлж:

Ерөнхий менежер Б.Одбаяр



964-1121

..... тоот гэрээний Хавсралт №2

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ТЭЭВЭРЛЭХ ТЭЭВРИЙН ҮНЭ

№	Машины марк, даац	Засмал зам	Шороон зам	Тайлбар
1	Хүнд даац: 25-30 тн Машины марк:	1км/4800 төг	1км/4800 төг	Үүсгэгч аюултай хог хаягдлыг тээврийн хэрэгсэлд ачих зардал ороогүй буулгах зардал орсон үнэ болно.
2	Бага даац: 3 тн, 5 тн Машины марк:	1км/3500 төг	1км/3500 төг	

Тайлбар:

1. Дээрх тээвэрлэлтийн хөлсөнд НӨАТ тооцоогүй үнэ бөгөөд тээвэрлэлтийн зардлыг 1 талд нь тооцсон үнэ болно.
 - 1.1 НҮБ-ын 2010 оны аргачлал, Монгол Улсын химийн бодисын тухай хууль, Монгол Улсын химийн аюултай ачаа тээвэрлэхтэй холбоотой MNS 4978:2000 стандарт, аюултай ачаа тээвэрлэх хууль, дүрэм, журамд заасан шаардлагыг хангасан тээврийн хэрэгслээр маршрутын дагуу хөдөлмөр аюулгүй ажиллагааг ханган тээвэрлэнэ.
 - 1.2 Аюултай хог хаягдал үүсгэгч аж ахуйн нэгж Аюултай хог хаягдлын савыг зохих журмын дагуу бүрэн сулласан байх, хоосон сав нь ЗГ-ын 2018 оны 116-р тогтоолын 1-р хавсралтын 5.7-5.9-д заасан шаардлагыг хангасан байвал зохино.

ХАВСРАЛТ БАТАЛСАН:**Үүсгэгчийг төлөөлж:**

ХТҮГ-ын Захирал Д.Нинжбадгар


Хүлээн авагчийг төлөөлж:

Ерөнхий менежер Б.Одбаяр



964-1121

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын
2018 оны 02 сарын 02-ны өдрийн А/21 дугаар
тушаалын 1 дүгээр хавсралт

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ХАЯГДЛЫН ДАГАЛДАХ БИЧИГ

№

Дагалдах бичгийн дугаар:

/ шаардлагатай тохиолдолд нэмэлт хуудас хэрэглэнэ. /

1. Үүсгэгчийн талаарх мэдээлэл:								
Аюултай хог хаягдал үүсгэгчийн бүртгэлийн дугаар:								
Аюултай хог хаягдал үүсгэгч байгууллагын нэр:								
2. Аюултай хог хаягдлыг хүлээлгэн өгсөн:								
Овог нэр	Албан тушаалтан	Гарын үсэг:	Огноо:					
.....	2021он сар.....өдөр					
3. Тээвэрлэгчийн талаарх мэдээлэл:								
1/ Тээврийн хэрэгслийн улсын дугаар: Тээвэрлэгчийн бүртгэлийн дугаар:.....								
4. Аюултай хог хаягдлын талаарх мэдээлэл:								
	Аюултай хог хаягдлын нэр	Аюулын ангилал зэрэглэл	Савлаганы бүлэг	Савны		Хэмжээ	Нэгж /кг Эсвэл/ ш	Аюултай хог хаягдлын код
				Дугаар	Төрөл			
1								
2								
3								
4								
4. Тээвэрлэх үед анхаарах нэмэлт зааварчилгаа, мэдээлэл:								
6. Аюултай хог хаягдлыг хүлээн авсан тээвэрлэгч :								
1. Овог нэр:.....			Гарын үсэг:.....			2021он сар.....өдөр		
7. Үл зохицол:								
8. Аюултай хог хаягдлыг хүлээн авагчийн талаарх мэдээлэл:								
Аж ахуйн нэгжийн нэр: “Түмэн-Эгшиг” ХХК								
“Түмэн-Эгшиг” ХХК бүртгэлийн дугаар: 0000001								
Аюултай хог хаягдлыг хүлээн авсан:								
Овог нэр : “Түмэн-Эгшиг” ХХК	Албан тушаал	Гарын үсэг/ тамга /	Огноо					
.....	2021 он сар ... өдөр					

БАТЛАВ: "МОНГОЛЫН АЛТ" (МАК) ХХК-ИЙН
ЕРӨНХИЙ ЛӨГЧ НЭМЭЛТ МҮҮН



БАТЛАВ: "ТҮМЭН-ЭГШИГ" ХХК-ИЙН
ГҮЙЦЭТН ЭХ ЗАХИРАЛ, ҮЙНЗӨРИГ



0964-1121 тоот гэрээний нэмэлт гэрээ

2024 оны 02 сарын 20-ны өдөр

№ 235-1124 Улаанбаатар хот

Нэг талаас Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдаж үйл ажиллагаа явуулж буй "Монголын Алт" (МАК) ХХК (Регистрийн дугаар: 2095025) (цаашид "Үүсгэгч" гэх), түүнийг төлөөлж Хангамж, техник үйлчилгээний газрын Захирал Д.Нинжбадгар,


Нөгөө талаас Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдаж, үйл ажиллагаа явуулж буй "Түмэн-Эгшиг" ХХК (Регистрийн дугаар: 5031923) (цаашид "Хүлээн авагч" гэх), түүнийг төлөөлж Ерөнхий менежер Б.Одбаяр нар (цаашид хамтад нь "Талууд" гэх) нь Монгол Улсын Иргэний хууль болон Талуудын хооронд 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдөр байгуулагдсан 0964-1121 тоот "Аюултай хог хаягдал шилжүүлэх гэрээ" (цаашид "Үндсэн гэрээ" гэх)-ний 9.3 дугаар зүйлийг тус тус үндсэн дараах гэрээ (цаашид "Нэмэлт гэрээ" гэх)-г байгуулж байна.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү Нэмэлт гэрээний зорилго нь Үндсэн гэрээний хүчин төгөлдөр хугацаа дууссантай холбогдуулан Үндсэн гэрээний 3.1-д заасан хугацааг сунгахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Энэхүү Нэмэлт гэрээ нь Талуудын эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болох бөгөөд Талууд Үндсэн гэрээ болон Нэмэлт гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлснээр дуусгавар болно.

ХОЁР. ҮНДСЭН ГЭРЭЭНД ОРУУЛАХ НЭМЭЛТ

- 2.1. Үндсэн гэрээний 3.1-д заасан хугацааг 1 (нэг) жил буюу 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдрөөс 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрийг хүртэл хугацаагаар сунгав.
- 2.2. Нэмэлт гэрээний 2.1-д заасан хугацаа дуусгавар болсны дараа Талууд харилцан тохиролцож нэмэлт гэрээ байгуулснаар Үндсэн гэрээг дахин 1 (нэг) жилийн хугацаагаар сунгагдсанд тооцно.



ГУРАВ. БУСАД ЗҮЙЛ

- 3.1. Энэхүү Нэмэлт гэрээ нь Үндсэн гэрээний салшгүй хэсэг болно.
- 3.2. Талууд энэхүү Нэмэлт гэрээг адил хүчинтэй 7 (долоо) хувь үйлдэж, Үүсгэгч 6 (зургаа) хувь, Хүлээн авагч 1 (нэг) хувийг хадгалсан нь хуулийн адил хүчинтэй байна.
- 3.3. Энэхүү Нэмэлт гэрээ хүчин төгөлдөр болсноор Талуудын хооронд байгуулсан Үндсэн гэрээний хугацаа сунгагдсанд тооцно.
- 3.4. Энэхүү Нэмэлт гэрээгээр зохицуулагдаагүй бусад харилцаа нь Талуудын хооронд байгуулагдсан 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 0964-1121 тоот Аюултай хог хаягдал шилжүүлэх гэрээний дагуу зохицуулагдана.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Үүсгэгчийг төлөөлж:

ХТҮГ-ын Захирал Д.Нинжбадгар

ЭЗГ-ын Ахлах хуульч Т.Жавхлан

Хүлээн авагчийг төлөөлж:

Ерөнхий менежер Б.Одбаяр



ЭМНЭЛГИЙН ТУСГАЙ ХОГ
ХАЯГДЛЫГ УСТГАХ ГЭРЭЭ

2023 он 05 сар 27 өдөр

№ 0115123

Мандах сум

Нэг талаас: “Эрдэнэс цагаан суварга” ХХК /цаашид “Захиалагч” гэх/, түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Г.Цогт,

Нөгөө талаас: Дорноговь аймгийн Мандах сумын Эрүүл мэндийн төв /цаашид “Гүйцэтгэгч” гэх/, түүнийг төлөөлж дарга Э.Чулуунцэцэг нар харилцан тохиролцож Эрүүл мэндийн тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Эрүүл мэндийн сайдын 2002 оны 249/201 тоот тушаал, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд болон Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2011 оны 05 сарын 03-ны өдрийн 158 дугаар тушаалыг тус тусыг үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

НЭГ. ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- 1.1 Энэхүү гэрээгээр Гүйцэтгэгч нь Дорноговь аймгийн Мандах сумын нутаг дэвсгэрт байрлах Цагаан суваргын уурхайн эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх байрнаас гарсан тусгай хог хаягдлыг холбогдох дүрэм, журам, стандартын дагуу устгах, Захиалагч нь гэрээгээр тохиролцсон үнийг Гүйцэтгэгчид төлөхтэй холбогдон үүсэх харилцаанд Талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхой болгон зохицуулна.
- 1.2 Эмнэлгийн тусгай хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах ажлыг стандарт шаардлагын дагуу мэргэжлийн түвшинд гүйцэтгэх, хог хаягдал түр хадгалах цэг болон хог хаягдал устгаж байгаа орчныг цэвэр байлгахад энэхүү гэрээний зорилго оршино.
- 1.3 Энэхүү гэрээ нь Хавсралт №1 – “Хог хаягдал хүлээлцэх маягтын загвар”-тай байх бөгөөд энэ нь гэрээний салшгүй хэсэг байна.
- 1.4 Энэхүү гэрээ нь Талуудын эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, тамга дарснаар хүчин төгөлдөр болно.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ҮНЭ, ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ, ХУГАЦАА.

- 2.1 Энэхүү гэрээг 2023 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн 2026 оны 5 дугаар сарын 1-ний өдөр хүртэл 3 жилийн хугацаанд дагаж мөрдөнө.
- 2.2 Гэрээний хугацаа дуусмагц гэрээг Талууд харилцан тохиролцож шинэчлэн байгуулж болно.
- 2.3 Гүйцэтгэгчийн ажилтан тусгай хог хаягдлыг устгалд оруулсан тухай бүр тэмдэглэлийг үйлдэх ба Эрүүл мэндийн төвийн даргын хяналт тавигдаж, гарын үсгээр баталгаажсан байна. Тэмдэглэлийн маягтыг гэрээнд хавсаргах бөгөөд энэ нь гэрээний салшгүй хэсэг байна.
- 2.4 Эмнэлгийн хог хаягдал устгасны 1 сарын төлбөр нь 10,000 төгрөг байна.

ГУРАВ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ.

- 3.1 Гүйцэтгэгч нь тусгай хог хаягдлыг устгах ажлыг Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, дүрэм журам, норм стандартын шаардлагад бүрэн нийцүүлэн хийж гүйцэтгэнэ.
- 3.2 Гүйцэтгэгч нь Захиалагчийн Цагаан суварга төслийн эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх байрнаас гарсан тусгай хог хаягдлыг стандартын дагуу уут, саванд хийх, устгах хүртэл хадгалах, битүүмжлэх, тээвэрлэх талаар мэргэжлийн зөвлөгөөг Захиалагчийн төлөөлөгчид өгөх үүрэгтэй.
- 3.3 Гүйцэтгэгч нь Захиалагчийн Цагаан суварга төслийн эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх байрнаас хүргэгдэн ирсэн тусгай хог хаягдлыг технологийн дагуу хүлээн авч хадгалсан сав, баглаа боодлын стандарт шаардлагад хяналт тавьж, шаардлага хангасан тохиолдолд хүлээн авна.
- 3.4 Тусгай хог хаягдлыг стандартын дагуу устгаж, устгал хийсэн тухай тэмдэглэлийг батлагдсан маягтын дагуу хөтлөн баталгаажуулсан 1 хувийг Захиалагчийн Цагаан суварга төслийн эмнэлгийн эмчид тухай бүр нь хүргүүлнэ.
- 3.5 Гүйцэтгэгч нь тусгай хог хаягдал устгасны төлбөрийн нэхэмжлэхийг улирал тутамд Захиалагчид хүргүүлнэ.
- 3.6 Гүйцэтгэгч нь тусгай хог хаягдлыг устгах ажлыг Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа



**ДОРНОГОВЬ АЙМАГ
БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103
Утас: (976) 7052 2663, факс: (02-522) 4-27-26
Цахим шуудан: Dgaboajg@do.mne.gov.mn
Цахим хаяг: www.do.mine.gov.mn

2024. 10. 02 № 61

танай 2024. 09. 19-ны № 01/133 -т

ЭРДЭНЭС ЦАГААН СУВАРГА ХХК-д

Танай компаниас ирүүлсэн аюултай хог хаягдал үүсгэгчийн бүртгэлд бүртгүүлэх тухай хүсэлтийг шийдвэрлэж, Y-001987 дугаар олгосон болохыг үүгээр мэдэгдэж байна. Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журмын хэрэгжилтийг хангаж, аюултай хог хаягдлын менежментийг хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж ажиллана уу.

ДАРГА  НОТГОНБАЯР



4424030074

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын
2018 оны 02 сарын 02-ны өдрийн А/21 дугаар
тушаалын 1 дүгээр хавсралт

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ХАЯГДЛЫН ДАГАЛДАХ БИЧИГ

№ *01/101*

Дагалдах бичгийн дугаар:

/шаардлагатай тохиолдолд нэмэлт хуудас хэрэглэнэ./

1. Үүсгэгчийн талаарх мэдээлэл:
Аюултай хог хаягдал үүсгэгчийн бүртгэлийн дугаар: *МАК Эрдэнэс Цэвэрэн Эвэрэгс ХХК*
Аюултай хог хаягдал үүсгэгч байгууллагын нэр: *МАК Эрдэнэс Цэвэрэн Эвэрэгс ХХК*

2. Аюултай хог хаягдлыг хүлээлгэн өгсөн:
Овог нэр: _____ Албан тушаалтан: _____ Гарын үсэг: _____ Огноо: 2024 он *07* сар *15* өдөр

3. Тээвэрлэгчийн талаарх мэдээлэл:
1/ Тээврийн хэрэгслийн улсын дугаар: *18-1476M* Тээвэрлэгчийн бүртгэлийн дугаар: *0000022*

4. Аюултай хог хаягдлын талаарх мэдээлэл:

	Аюултай хог хаягдлын нэр	Аюулын ангилалын зэрэглэл	Савлагааны бүлэг	Савны		Хэмжээ	Нэгж /кг Эсвэл/ ш	Аюултай хог хаягдлын код
				дугаар	Төрөл			
1	<i>Аж ахуйн нэгжийн хог</i>	<i>X</i>				<i>10500</i>	<i>кг</i>	<i>105018</i>
2								
3								
4								

3. Тээвэрлэх үед анхаарах нэмэлт шаардлага, мэдээлэл: *Эвэрэгс Эвэрэгс ХХК-н хөрөнгө*

5. Аюултай хог хаягдлыг хүлээн авсан тээвэрлэгч: *Эвэрэгс Эвэрэгс ХХК*

1. Овог нэр: *В. Эвэрэгс* Гарын үсэг: *В. Эвэрэгс* 2024 он *07* сар *15* өдөр

6. Үл зохицол: *гүйц*

8. Аюултай хог хаягдлыг хүлээн авагчийн талаарх мэдээлэл:
Аж ахуйн нэгжийн нэр: **ТҮМЭН ЭГШИГ ХХК**
Түмэн эгшиг ХХК бүртгэлийн дугаар: **-000022**
Аюултай хог хаягдлыг хүлээн авсан:
Овог нэр: Түмэн эгшиг ХХК Албан тушаал: _____ Гарын үсэг: _____ Огноо: 2024 он *07* сар *15* өдөр



Монгол улсын эрүүл мэндийн сайдын тушаал 2017 оны 12 сарын 12 өдрийн А/505 тушаал

**Эрдэнэс цагаан суварга зэсийн уурхайн төслийн эрүүл мэндийн тусламж үзүүлэх нэгжийн хог хаягдал
устгуулсан тухай акт**

Эмнэлгийн хог хаягдлыг боловсруулах , устгах байгууламжид хүлээлгэн өгөх бүртгэлийн маягт

2024 он 05 сар 02 өдөр

Тээврийн хэрэгслийн дугаар: 8420 ЧАВ

Жолоочийн нэрг, утас: Амармуну 80065998

Эрүүл мэндийн байгууллагын нэр	Халдвартай хог хаягдал /кг /	Хурц үзүүртэй иртэй хог хаягдал /кг /	Эмгэг хог хаягдал	Эмийн болон эсэд хортой хог хаягдал	Хүлээлгэн өгсөн хүний гарын үсэг	Хүлээн авсан хүний гарын үсэг
Мөнхсайх сүлжээ ЭМТӨБ	1,8 кг	1,2 кг	—	—	Б.Доржпү	

Эрдэнэ цагаан суварга уурхайн эрүүл мэндийн тусламж үзүүлэх нэгжийн хог хаягдал устгуулах тухай акт

Эмнэлгийн хог хаягдлыг боловсруулах, устгах байгууламжид хүлээлгэн өгөх бүртгэлийн маягт

2024 он 6 сар 4 өдөр

Тээврийн хэрэгслийн дугаар: 78-51 444

Жолоочийн нэр, утас: Б.Бай-Түвшин

Эрүүл мэндийн байгууллагын нэр	Халдвартай хог хаягдал /кг/	Хурш үзүүртэй иртэй хон заагдал /кг/	Эмгэг хог хаягдал	Эмийн болон эсэд хортой хог хаягдал	Хүлээлгэн өгсөн хүний гарын үсэг	Хүлээн авсан хүний гарын үсэг
Цагдаагийн алба АИТОВ БББ0001 902034	5,6 кг	-	-	-	[Signature]	[Signature]


Эрдэнэ цагаан суварга уурхайн эрүүл мэндийн тусламж үзүүлэх нэгжийн хог хаягдал устгуулах тухай акт

Эмнэлгийн хог хаягдлыг боловсруулах, устгах байгууламжид хүлээлгэн өгөх бүртгэлийн маягт

2024 он 07 сар 29 өдөр

Тээврийн хэрэгслийн дугаар: 68-23 УНЭ

Жолоочийн нэр, утас: Б. Амрагч

Эрүүл мэндийн байгууллагын нэр	Халдвартай хог хаягдал /кг/	Хурц үзүүртэй иртэй хон хаягдал /кг/	Эмгэг хог хаягдал	Эмийн болон эсэд хортой хог хаягдал	Хүлээлгэн өгсөн хүний гарын үсэг	Хүлээн авсан хүний гарын үсэг
Манга Х Сүх ЗТТ	3,800 кг	1 / 300 кг				Б.Амрагч



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohzt1@gmail.com

СОРИЛТЫН ДҮН



Дугаар он/№ : 2024/A-291
Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : "Эрдэнэс Цагаан Суварга" ХХК
Сорьцын авсан хүний нэр, албан тушаал : Д.Сувд агаарын хэсэг
Сорьцын тоо, төрөл : 5 агаар, 5 тоос
Сорьц авсан огноо : 2024.09.23-24
Сорьцын тодорхойлолт : Дорноговь аймаг Мандах сум
Шинжилгээний аргын стандарт : MNS 17-2-5-12:2021, MNS 17-2-5-11:2021
MNS 5002:2000, CA3 A07-2016
Шинжилсэн огноо : 2024.09.29
Хуудасны тоо : 1/1

Үр дүн :

№	Сорьц авсан цэг	Сорьц авсан өдөр	Сорьц авсан цаг	Хүхэрлэг хий	Азотын давхар исэл		Нийт тоос /TSP/
					мг/м ³		
1	TS-A-4	IX/23	18:20	0.013	0.021	0.120	
2	TS-A-5	IX/24	10:40	0.011	0.024	0.114	
3	TS-A-3	IX/24	14:10	0.015	0.028	0.326	
4	TS-A-2	IX/24	14:10	0.011	0.025	0.120	
5	TS-A-1	IX/24	14:40	0.010	0.027	0.087	
Агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016 Зөвшөөрөгдөх дээд хэмжээ (20 минутын хэмжилт)				0.450	0.200	0.500	

Шинжилгээ гүйцэтгэсэн шинжээч:

Хянаж баталгаажуулсан:

Байгаль орчны шинжилгээний хэлтсийн дарга



Э.Оюунтуяа

Б.Бархасрагчаа

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцод хүчинтэй



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohzt@gmail.com

СОРИЛТЫН ДҮН



Дугаар он/№ : 2024/A-291
Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : "Эрдэнэс Цагаан Суварга" ХХК
Сорьц авсан хүний нэр, албан тушаал : Д.Сувд агаарын хэсэг
Сорьцын тоо, төрөл : 1 тоос, тоосонцор
Сорьц авсан огноо : 2024.09.22-23
Сорьцын тодорхойлолт : Дорноговь аймаг Мандах сум
Шинжилгээний аргын стандарт : САЗ А07-2016
Шинжилсэн огноо : 2024.09.29
Хуудасны тоо : 1/1
Үр дүн :

№	Сорьц авсан цэг	Сорьц авсан өдөр	PM2.5	PM10	TSP
			мг/м ³		
1	ЗҮТ TS-A-6	IX/22-23	0.091	0.102	0.105
Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 (хоногийн хэмжилт)			0.050	0.100	0.150

Шинжилгээ гүйцэтгэсэн шинжээч:

Хянаж баталгаажуулсан:
Байгаль орчны шинжилгээний хэлтсийн дарга



Э.Оюунтуяа

Б.Бархасрагчаа

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцод хүчинтэй



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohzt1@gmail.com



СОРИЛТЫН ДҮН

Дугаар он/№ : 2024/A-290
Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : "Эрдэнэс Цагаан Суварга" ХХК
Сорьц авсан хүний нэр, албан тушаал : Д.Сувд агаарын хэсэг
Сорьцын тоо, төрөл : 4 дуу чимээ
Сорьц авсан огноо : 2024.09.23
Сорьцын тодорхойлолт : Дорноговь аймаг Мандах сум
Шинжилгээний аргын стандарт : САЗ А07-2016
Шинжилсэн огноо : 2024.09.29
Хуудасны тоо : 1/1
Үр дүн :

№	Сорьц авсан цэг	Сорьц авсан өдөр	Сорьц авсан цаг	Дуу чимээ /ДБА/
1	TS-A-3	IX/23	11:20	56
2	TS-A-4	IX/23	12:10	42
3	TS-A-2	IX/23	12:30	56
4	TS-A-1	IX/23	13:00	52
Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 (20 минутын хэмжилт)				60

Шинжилгээ гүйцэтгэсэн шинжээч:

Хянаж баталгаажуулсан:

Байгаль орчны шинжилгээний хэлтсийн дарга



Э.Оюунтуяа

Б.Бархасрагчаа

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцод хүчинтэй



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohzt1@gmail.com



СОРИЛТЫН ДҮН

Дугаар он/№ : 2024/A-290
Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : "МАК Аранжин Зэс" ХХК
Сорьцын авсан хүний нэр, албан тушаал : Д.Сувд агаарын хэсэг
Сорьцын тоо, төрөл : 6 агаар, 6 тоос
Сорьц авсан огноо : 2024.09.24
Сорьцын тодорхойлолт : Дорноговь аймаг Мандах сум
Шинжилгээний аргын стандарт : MNS 17-2-5-12:2021, MNS 17-2-5-11:2021
MNS 5002:2000, CA3 A07-2016
Шинжилсэн огноо : 2024.09.29
Хуудасны тоо : 1/1
Үр дүн :

№	Сорьц авсан цэг	Сорьц авсан өдөр	Сорьц авсан цаг	Хүхэрлэг хий	Азотын давхар исэл		Нийт тоос /TSP/
					мг/м ³		
1	SWEX-A-9	IX/24	11:10	0.010	0.029	0.078	
2	SWEX-A-8	IX/24	11:35	0.009	0.034	0.216	
3	SWEX-A-2	IX/24	12:00	0.012	0.030	0.093	
4	SWEX-A-1	IX/24	12:25	0.010	0.028	0.156	
5	SWEX-A-6	IX/24	12:50	0.014	0.022	0.180	
6	SWEX-A-10	IX/24	15:10	0.011	0.020	0.260	
Агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016				0.450	0.200	0.500	
Зөвшөөрөгдөх дээд хэмжээ (20 минутын хэмжилт)							

Шинжилгээ гүйцэтгэсэн шинжээч:

Хянаж баталгаажуулсан:
Байгаль орчны шинжилгээний хэлтсийн дарга



Э.Оюунтуяа

Б.Бархасрагчаа

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцод хүчинтэй



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohzt@gmail.com



СОРИЛТЫН ДҮН

Дугаар он/№	: 2024/A-290
Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас	: "МАК Аранжин Зэс" ХХК
Сорьц авсан хүний нэр, албан тушаал	: Д.Сувд агаарын хэсэг
Сорьцын тоо, төрөл	: 5 дуу чимээ
Сорьц авсан огноо	: 2024.09.22
Сорьцын тодорхойлолт	: Дорноговь аймаг Мандах сум
Шинжилгээний аргын стандарт	: САЗ А07-2016
Шинжилсэн огноо	: 2024.09.29
Хуудасны тоо	: 1/1
Үр дүн :	

№	Сорьц авсан цэг	Сорьц авсан өдөр	Сорьц авсан цаг	Дуу чимээ /ДБА/
1	SWEX-A-4	IX/22	18:20	38
2	SWEX-A-3	IX/22	18:40	50
3	SWEX-A-1	IX/22	19:10	53
4	SWEX-A-2	IX/22	19:25	51
5	SWEX-A-6	IX/22	20:05	40
Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 (20 минутын хэмжилт)				60

Шинжилгээ гүйцэтгэсэн шинжээч:

Хянаж баталгаажуулсан:
Байгаль орчны шинжилгээний хэлтсийн дарга



Э.Оюунтуяа

Б.Бархасрагчаа

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцод хүчинтэй

БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

Дугаар, он /№ : 2024/28
Сорьцыг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : “Эрдэнэс цагаан суварга” ХХК
Сорьцыг авсан хүний нэр, албан тушаал : Б. Сумъяасүрэн /Лабораторийн тенхикч/
Сорьцын төрөл, тоо : SO₂-4, NO₂-4, Нийт тоос-4
Хүлээн авсан огноо : 2024.06.04
Сорьцын тодорхойлолт : Дорноговь аймаг, Мандах сум
Шинжилсэн огноо : 2024.06.04-06.06
Хуудасны тоо : 1

Үр дүн

№	Дээж авсан цэгийн нэр	Хүхэрлэг хий, SO ₂ мг/м ³	Азотын давхар исэл, NO ₂ мг/м ³	Нийт тоосны агууламж мг/м ³
1	Дотоод тээврийн зам N 43°52'47.0 E 108°21'09.9	0.003	0.030	0.125
2	Засвар Үйлчилгээний төв N 43°52'38.4 E 108°20'28.3	0.004	0.033	0.990
3	Бутлуурын орчин N 43°52'21.7 E 108°20'33.6	0.003	0.025	0.409
4	Хогийн цэгийн орчин N 43°51'11.4 E 108°22'43.9	0.002	0.018	0.630
ЗДХ	MNS4585:2016	0.450	0.200	0.500

Тайлбар: Хэмжилт хийх хугацаанд шороон шуургатай байсан учир тоос тоосонцор хэт өндөр гарсан болно.

Шинжилгээ гүйцэтгэсэн лабораторийн инженер: Т. Түмэннаст
Хянаж баталгаажуулсан УЦУОШТөвийн дарга: Т. Азбаяр



Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.


ДОРНОГОВЬ АЙМГИЙН УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ


ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

Дугаар, он /№ : 2024/31
Сорьцыг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : “Эрдэнэс цагаан суварга” ХХК
Сорьцыг авсан хүний нэр, албан тушаал : Б. Сумъяасүрэн /Лабораторийн тенхикч/
Сорьцын төрөл, тоо : Хөрс агрохими-6
Хүлээн авсан огноо : 2024.06.04
Сорьцын тодорхойлолт : Дорноговь аймаг, Мандах сум
Шинжилсэн огноо : 2024.06.04-06.17
Хуудасны тоо : 1

Үр дүн

№	Цэгийн нэр	pH	Чийг %	Нитратын азот /NO ₃ / мг/кг	Сульфат /SO ₄ / мг/кг	Фосфор /P ₂ O ₅ / мг/кг	Амиакийн азот /NH ₄ / мг/кг	Ялзмаг Мг/кг
1	Ажилчдын Кемп N 43°53'02.7 E 108°20'31.0	8.67	0.96	15.453	203.1	2.04	39.38	0.65
2	ШТС-ын орчин N 43°52'41.2 E 108°20'43.6	9.50	1.12	5.959	19.8	1.89	66.45	0.90
3	Хогийн цэгийн орчин N 43°51'11.4 E 108°22'43.9	9.54	0.80	19.392	25.7	1.16	73.83	2.09
4	Хөрсний овоолго N 43°52'41.2 E 108°20'43.6	9.58	1.80	7.956	37.7	1.62	348.77	3.06
5	Шимт хөрс N 43°51'37.6 E 108°19'17.7	9.16	0.34	10.201	36.2	1.02	767.00	1.55
6	Харьцуулах хөрс N 43°38'25.6 E 108°43'52.1	9.14	1.10	18.786	29.5	2.69	58.24	1.62

Шинжилгээ гүйцэтгэсэн лабораторийн инженер:  Ч. Түмэннаст

Хянаж баталгаажуулсан УЦУОШТөвийн дарга  Т. Азбаяр

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ**

ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

Дугаар он /№ : 2024/29
 Сорьцыг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : “Эрдэнэс цагаан суварга” ХХК
 Сорьцыг авсан хүний нэр, албан тушаал : Б. Сумъяасүрэн /Лабораторийн тенхикч/
 Сорьцын тоо, төрөл : 3 Ус
 Хүлээн авсан огноо : 2024.06.04
 Сорьцын тодорхойлолт : Дорноговь аймаг, Мандах сум
 Шинжилсэн огноо : 2024.06.04-06.07
 Хуудасны тоо : 1

Үр дүн

№	Сорьцын үзүүлэлтүүд	Гал тогооны ус /нөөц/ N 43°52'51.3 E 108°20'42.9	Гүний худаг N 44°00'04.1 E 108°26'02.1	Цэвэршүүлсэн ус N 43°36'10.3 E 108°35'29.7	MNS 0900:2018
1	Усан орчин /рН/	8.12	8.18	8.07	6.5-8.5
2	Цахилгаан дамжуулах чанар /ЕС/ μS/cm/	1884	1814	1887	-
3	Кальцийн ион /Ca/ мг/л	4.45	13.35	11.86	100
4	Магнийн ион /Mg/ мг/л	9.00	5.35	3.65	30
5	Натри+Калийн ион /Na+K/ мг/л	362	355	368	-
6	Сульфатын ион /SO ₄ / мг/л	206	198	214	500
7	Хлорын ион /Cl/ мг/л	239	229	226	350
8	Гидрокарбонатын ион /HCO ₃ / мг/л	268	287	293	-
9	Эрдэжилт мг/л	1088	1089	1117	-
10	Хатуулаг экв/л	0.96	1.11	0.89	7.0
11	Жинлэгдсэн бодис	8.6	илр	3.8	-
12	Перманганатын исэлдэх чанар мг/л	0.9	0.8	0.8	-
13	Аммонийн азот /NH ₄ / мг/л	0.08	0.05	0.06	1.5
14	Нитритийн азот /NO ₂ / мг/л	0.009	0.003	0.008	1
15	Нитратийн азот /NO ₃ / мг/л	3.43	3.41	3.45	50
16	Эрдэс фосфор /PO ₄ ³⁻ / мг/л	0.005	0.004	0.005	3.5
17	Фтор /F/ мг/л	3.38	3.39	3.40	0.7-1.5
18	Төмөр /Fe/ мг/л	0.04	0.01	0.03	0.3

Шинжилгээ гүйцэтгэсэн лабораторийн инженер:

Ч. Түмэннаст

Хянаж баталгаажуулсан УЦУОШТөвийн дарга

Т. Азбаяр



Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
 Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй